



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй
өнөөгийн байдал, үр дүн”-д
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2020/03/-ГА

Чойбалсан хот 2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Гэрээт аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn
Гэрээт аудитор З.Шинэхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦЭХГҮЙ БАЙНА.	6
А.1 Ерөнхий боловсрол олгож буй хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.	6
А.1.1 БСШУЯ нь Боловсролын тухай хууль, тогтоомжид заасан журмуудыг бүрэн батлаагүй байна.	6
А.1.2 Багшийн ажлын норм, нормативтай холбоотой хууль, дүрмийн заалтуудыг бага боловсрол олгох бодлого, хөтөлбөртэй уялдуулах шаардлагатай байна.	8
А.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахад мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ болон материаллаг орчныг сайжруулах шаардлагатай байна.	9
А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчин бүрдсэн ч шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалж хамрагдалт харилцан адилгүй	9
А.2.2 Ерөнхий боловсрол олгоход шаардлагатай материаллаг орчин хангалттай бүрдээгүй байна.	13
А.2.3 Аймгийн хэмжээнд зарим мэргэжлийн багш нар дутагдалтай байна.	18
А.3 Сургуулиудын төсвийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.	20
А.3.1 Төсвийн төлөвлөлтөд баримталж буй норм, норматив бодит нөхцөлд нийцэхгүй, аргачлал дутмаг байгаагаас хуваарилалт тэгш хүртээмжтэй хийгдэхгүй байна.	20
А.3.2 Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил гарсаар байна.	26
БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД БАЙНА.	28
Б.1 Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна.	28
Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч суурь боловсролын чанар хангалтгүй дүгнэгдсэн байна.	28
Б.1.2 Сургалтын чанарыг бодитой үнэлж байгаа ч БҮТ-өөс дүгнэлтийг танилцуулах зөвлөмж өгч, чанарыг сайжруулах ажил хангалттай хийгдээгүй байна.	34
Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч үр дүнг тооцож ажиллахгүй байна.	36
Б.2.1 Байгууллагын түвшинд дотоод хяналт бүрэн хэрэгжихгүй, үр дүнг тооцохгүй байна.	37
Б.2.2 Эцэг эхийн зөвлөлийн хяналт хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байна.	38
Холбогдох байгууллагын санал.	39
Саналд өгсөн тайлбар.	41
ДҮГНЭЛТ:	41
ЗӨВЛӨМЖ:	42
ТУШААЛ.	44



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчит газар
ХШҮХ	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ДИС	Дорнод Их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Сургуулиудын хүчин чадлыг сурагчдын тоонд харьцуулсан судалгаа”	10
Хүснэгт 2	“Нэг ангид ногдох дундаж хүүхдийн тоог байршил, хэв шинж, чанарын үзүүлэлтээр харьцуулсан судалгаа 2019-2020 оны хичээлийн жил”	12
Хүснэгт 3	“Гадаад эрсдэлийн судалгаа”	16
Хүснэгт 4	“Сургалтын компьютерын хангалтын судалгаа”	17
Хүснэгт 5	“Багшийн хэрэгцээний судалгаа /сургууль бүрээр/	19
Хүснэгт 6	“Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал”	23
Хүснэгт 7	“Харьцуулсан бараа үйлчилгээний бусад зардал”	24
Хүснэгт 8	“Дорнод аймгийн ЕБС-ийн элсэлтийн ерөнхий шалгалтын сүүлийн 4 жилийн байр эзэлсэн дүн”	29
Хүснэгт 9	“Чанарын үнэлгээ – суурь боловсрол 2019”	30
Хүснэгт 10	“Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалтын сүүлийн 3 жилийн дунджаар байр эзлэлт”	32

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“Санал асуулгын дүн”	15
Дүрслэл 2	“Санал асуулгын дүн”	18
Дүрслэл 3	“Багш, ажилтнуудын тоо”	18
Дүрслэл 4	“Багш нарын боловсрол түвшин”	18
Дүрслэл 5	“Дутагдалтай мэргэжил”	19
Дүрслэл 6	“Нийт хувьсах зардал”	22
Дүрслэл 7	“Төсвийн хуваарилалт”	23
Дүрслэл 8	“Санал асуулгын дүн”	25
Дүрслэл 9	“Аймгуудын дундажтай харьцуулсан үнэлгээ”	28
Дүрслэл 10	“Улсын дундажтай харьцуулсан үнэлгээ”	30
Дүрслэл 11	“Улсын дундажтай харьцуулсан үнэлгээ”	31
Дүрслэл 12	“Санал асуулгын дүн”	33
Дүрслэл 13	“Санал асуулгын дүн”	33
Дүрслэл 14	“Санал асуулгын дүн”	34
Дүрслэл 15	“Санал асуулгын дүн”	35
Дүрслэл 16	“Санал асуулгын дүн”	36



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Дорнод аймгийн хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн ЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, Боловсрол, соёл, урлагийн газар, төрийн 19, хувийн өмчийн 1 нийт 20 ЕБС-ийн 2016-2019 оны үйл ажиллагааг /2016-2017, 2017-2018, 2018-2019 буюу сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, санал асуулга авах, цуглуулсан судалгааны баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж гүйцэтгэлээ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн, З.Шинэхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын дэд төлөвлөгөөг 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдөр батлуулж, талбарын үе шатны ажлыг 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүргүүлээ.



БҮЛЭГ А. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

А.1. Ерөнхий боловсрол олгож буй хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

А.1.1 БСШУЯ нь боловсролын тухай хууль, тогтоомжид заасан журмуудыг бүрэн батлаагүй байна.

- *Хуульд заасан дүрэм, журам, норм нормативыг баталсан уу?*

Бүх нийтэд ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа нь “Боловсролын тухай хууль”, “Бага дунд боловсролын тухай хууль”, “Багшийн хөгжлийн тухай хууль”, УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах 2014-2024 оны бодлого болон холбогдох бусад эрх зүйн актуудын хүрээнд зохицуулагдаж байна.

Бага дунд боловсролын тухай хуульд ерөнхий боловсролын сургуулийг ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай гэсэн хэв шинжтэй байхаар заасан байна.

Дорнод аймагт ерөнхий боловсролын ердийн сургалттай 23, ердийн болон гүнзгийрүүлсэн сургалттай 6 нийт 27 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас улсын хэвшлийн 23, хувийн хэвшлийн 4 сургууль байна.

Боловсролын тухай хуулийн 3.1.14.-т “*ерөнхий боловсролын лаборатори сургууль гэж бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийг;*” гэж заасан бөгөөд мөн хуулийн 28.1.25-д “*төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж батлах бүрэн эрхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ*” гэж заасан боловч уг журмыг боловсруулж, батлаагүй байна.

Боловсролын тухай хуулийн 39.12. “*Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална*” гэж заасан боловч энэхүү журам батлагдаагүй байна. Энэ нь сургуулиудын нэмэлт орлого олж үйл ажиллагаандаа зарцуулах идэвх санаачилга, боломжийг бууруулж байна. Тухайлбал: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар дунд, ахлах ангийн сурагчдыг эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах зорилгоор “Жаргалан кафе” төслийг 2018 оноос нийт сургуулиудад хэрэгжүүлсэн боловч эрх зүйн орчин хангалтгүйгээс үйл ажиллагаагаа нь сургууль бүрд харилцан адилгүй, бүрэн жигдэрч чадаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн 346 дугаар тогтоолд “*Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах, гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах, туслах аж ахуй эрхлэх, цайны газар болон биеийн тамирын заалыг түрээслэх зэрэг хуулиар хориглоогүй, үндсэн чиг үүрэгтэй нь зөрчилгүй, суралцагчийн эрх ашигт хохиролгүй бусад үйл ажиллагааг эрхэлж нэмэлт орлого олох, багш, ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэхэд зориулан зарцуулах эрхийг төсвийн шууд захирагчид нээж өгөхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус зөвшөөрсүгэй*” гэж заасан боловч энэхүү тогтоол нь Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолоор хүчингүй



болж, шинэ тогтоолд нэмэлт орлого олох, зарцуулах талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд нь биеийн тамирын заал түрээслэх үйл ажиллагаанаас олсон бага хэмжээний орлогыг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-аар зарцуулж байгаа ч нэмэлт орлого олох үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл тодорхой бус байгаа нь орлогоо нэмэгдүүлэх, гэрээ байгуулах, нягтлан бодох бүртгэлд тусгах зэрэгт хүндрэл учруулж байна. Энэ нь боломжит орлогыг алдах, түрээсийн орлогыг шамшигдуулах эрсдэлтэй байна.

Салбар яамны захиргааны хэм хэмжээний зарим актууд хэрэгжихгүй байна. Үүнд:

Боловсролын тухай хуулийн 8.2-т “Тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даан эзэмших зорилгоор бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болох бөгөөд уг хөтөлбөрийн агуулга, сургалт явуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална, 17.2-т Аймаг, нийслэл, сум, дүүрэгт насан туршийн болон албан бус сургалтыг зохион байгуулах, бие даан суралцагчид туслах үүрэг бүхий албан бус боловсролын төвийг бие даасан хэлбэрээр, эсхүл сургалтын байгууллагыг түшиглүүлэн ажиллуулна” гэж заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний А/286 тоот захирамжаар “Дорнод аймгийн насан туршийн боловсролын төв” байгуулагдсан байна.

Тус төв нь БСШУС-ын сайдын тушаалаар баталсан “Бага, суурь, бүрэн дунд сургуулийн дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ын дагуу дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулж чадахгүй байна. Учир нь тус төвийн бүтэц орон тоог 6 хүний бүрэлдэхүүнтэй баталсан боловч санхүүгийн эх үүсвэр нь зөвхөн төсвөөс олгож байгаа нэг хүний цалингаар батлагддаг байна.

Энэ нь дээрх журмын 2.3.3-т “Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах байр танхим, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх,” 2.3.4-т “Сургалт зохион байгуулах багш багшлах эрхтэй, дүйцсэн хөтөлбөрийн агуулга, холимог бүлгийн арга зүйн сургалтад хамрагдсан байх,” 2.3.5-д “Сургалтын зохион байгуулалтын зардлыг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаас гадна хөтөлбөр төсөл, хандив, тусламж, хамтрагч байгууллагын дэмжлэг бүхий санхүүгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байх” гэж заасан сургалт зохион байгуулагчид тавигдах шаардлагуудыг хангаж чадахгүй байна.

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг одоогийн байдлаар аймгийн төвийн 3, сумын 2 сургууль өөрийн нөхцөл боломжид тулгуурлан явуулж байна.

- Салбарын яам захиргааны хэм хэмжээний актад холбогдох талуудын саналыг тусгасан уу? /эрх ашиг нь хөндөгдөх, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайлан, зөвлөмж, мэргэжлийн судлаач эрдэмтэд зэрэг/

Салбар яамны захиргааны хэм хэмжээний актад сургуулийн багш, ажилчдын саналыг авдаг байна.

- Мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинэчилсэн үү? /Налайх, Багануур, СХД-ийн захын сургуулиуд/

Орон нутагт хамааралгүй.

- Холбогдох дүрэм, журам, норм норматив, стандартыг бүрэн боловсруулж, баталсан уу?



Сургуулиуд нь салбар яамны захиргааны хэм хэмжээний акттай холбоотой өөрсдийн баталбал зохих дүрэм, журам, норм нормативыг бүрэн боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Тухайлбал: Сургуулийн дүрэм, дотоод журам, заах аргын нэгдлийн ажиллах журмуудыг батлан мөрдөж байна.

А.1.2 Багшийн ажлын норм, нормативтай холбоотой хууль, дүрмийн заалтуудыг бага боловсрол олгох бодлого, хөтөлбөртэй уялдуулах шаардлагатай байна.

- *ЕБС-ийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, ерөнхий боловсролын чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайланд үндэслэсэн үү?*

Орон нутагт хамааралгүй.

- *Ерөнхий боловсролын талаарх бодлого хөтөлбөр харилцан уялдаатай байна уу?*

Бага, дунд боловсролын тухай хуулийн 12.4-т “Ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлнэ” гэсэн заалт болон БСШУ-ны сайдын 471-р тушаалаар баталсан ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэмд “Сургууль хамран сургах тойргийнхоо суурь боловсрол эзэмших насны хүүхдийг сургууль завсардуулахгүй сургах, сургууль завсардсан хүүхдийг сургуульд буцаан суралцуулах ажлыг зохион байгуулна” гэж заасны дагуу хамран сургах тойргийн бүх хүүхдийг сургуульд хамруулахад сургуулийн хүчин чадлаас шалтгаалж анги дүүргэлтийг норматив хэмжээнд байлгах боломж байхгүй байна. Энэ нь багшийн ачааллыг нэмэгдүүлэх, хүүхэд нэг бүртэй ажиллах боломжийг бууруулах, суралцах орчныг бүрдүүлэхэд сөрөг нөлөөтэй байна.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтуудаар сургуулиудад өргөтгөл барин асуудлыг шийдэх арга зам хайж байгаа хэдий ч хүн амын өсөлт, төсвийн даацаас шалтгаалж анги дүүргэлтийг багасгах боломж богино хугацаанд хангагдахааргүй байна.

Аймгийн төвийн хэмжээнд бага ангийн анги дүүргэлт 40-45 хүүхэдтэй байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журамд “Анги дүүргэлтийг бага ангид 30-35” байна гэж заасан бол “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн 8.4-т “Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно” гэж заасан нь бага бүлгийн анги дээд хязгаарыг тодорхой бус болгож байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн туслах багш гэсэн орон тоо байхгүй нь энэ хуулийн заалтыг хэрэгжих боломжгүйд хүргэж байна.

Иймд сургалтын бодлого, хөтөлбөр, хууль, журмын заалтуудыг бодит нөхцөл байдалд нийцүүлэн уялдуулж зайлшгүй тохиолдолд туслах багш нэмж ажиллуулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

А.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахад мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ болон материаллаг орчныг сайжруулах шаардлагатай байна.

А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчин бүрдсэн ч шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалж хамрагдалт харилцан адилгүй байна.

- *Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-аас төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй байх*



Боловсролын тухай хуулийн 29.1.2¹-д заасан чиг үүргийн хүрээнд аймгийн ИТХ-аас 2016 оноос эхлэн дараах хөтөлбөр, төслийг батлан, хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Багшийн хөгжлийг дэмжих, багш нарыг ая тухтай ажиллах боломжоор хангах “Эрдэм” дэд хөтөлбөр, “Багшийн хөгжлийн төв” төсөл,
- Хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжих “Хүн болох багаасаа” дэд хөтөлбөр,
- Дунд ахлах ангийн сурагчдад эрүүл, аюулгүй хоол, хүнсээр үйлчлэх “Жаргалан кафе” төсөл,
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэл, гэмтлээс урьдчилан сэргийлэх “Сургууль, цэцэрлэгийн бүс” төсөл,
- Суралцагчдын эрүүл аюулгүй байдлыг хангах “Хүүхдэд ээлтэй орчин” төсөл,
- Бага ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээнд тулгуурлан сурч хөгжих ая тухтай орчныг бүрдүүлэх зорилготой “Манай анги” төслүүд байна.

Аймгийн ИТХ-аас хөтөлбөр, төслийн үр дүнг үнэлэх зорилгоор 2019 оны 10 дугаар сард аймгийн бүх сургуулиудыг хамруулсан хяналт, шалгалтыг зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.

Аудитаар төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үзэхэд дараах байдалтай байна.

- “Эрдэм” хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд багш, удирдах ажилтны гадаад, дотоодын сургалтад хамрагдахад 58.0 сая төгрөг зарцуулж, багшийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд 2018, 2019 онд 14 багшид 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 8 сургууль 37 багшийн зээл чөлөөлөх, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, орон байрны түрээсийн төлбөр, зээлийн хөнгөлөлт эдлэх зэрэг амьдралын орчин нөхцөлөө сайжруулах тэтгэлэгт хамруулсан байна.
- “Хүн болох багаасаа” дэд хөтөлбөрийг таниулах, хэрэгжилтийг сурталчилсан гэр бүлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх 7 цуврал теле нэвтрүүлэг, хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг дэмжих, зөв дадал хэвшил, хандлагыг хэвшүүлэхэд чиглэсэн “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Хүүхдийн бие даан суралцах дадал хэвшилд суралцах”, “Уламжлалт цагаан сарын баярыг зөв зохистой тэмдэглэн өнгөрүүлэх” 3 шторкийг тус тус хийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, иргэд, олон нийтэд сурталчилсан байна.
- “Жаргалан кафе” төслийг хэрэгжүүлж, 2018-2020 онд 22 сургуульд 118.0 сая төгрөгөөр буфет байгуулж, хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн, стандарт шаардлага хангасан орчинд эрүүл, аюулгүй хоол хүнсээр үйлчлэх нөхцөл бий болсон байна.
- “Сургууль, цэцэрлэгийн бүс” төслийн хүрээнд 411.0 сая төгрөгийг зарцуулж, сургууль, цэцэрлэгийн орчны гэрэлтүүлэг, камер, замын хөдөлгөөний тэмдэг, ногоон бүс тогтоох ажлыг үе шаттай шийдвэрлэсэн байна.
- “Хүүхдэд ээлтэй орчин” төслийн хүрээнд 1464.5 сая төгрөгийг зарцуулж, аймгийн 13 сумын сургууль, цэцэрлэгийн дотуур байрууд стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгосон нь ашиглалт хэвийн байна. Энэ нь хүйтний улирал дахь бага ангийн хүүхдүүдийн өвчлөлийг бууруулах эерэг нөлөөтэй байна.
- Аймгийн нийт сургууль, цэцэрлэгүүдэд 2016-2020 онд “Багш хөгжлийн төв”-ийг 341.6 сая төгрөгөөр байгуулсан тогтмол үйл ажиллагаатай байгаа бөгөөд 1100 гаруй багшийг ажлын байрны ая тухтай орчинд ажиллах боломжоор хангасан байна.
- Бага ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээнд тулгуурлан сурч, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор 2020 онд 158.8 сая төгрөгөөр аймгийн бүх сургуулиудад “Манай анги” төслөөр жишиг анги байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн байна.

- *ЕБС батлагдсан нормд хүрээгүй, анги танхимын дүүргэлт хангалтгүй байх /хүчин чадлыг бүрэн ашиглаагүй, цөөн хүүхэдтэй анги, сургууль/*

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-ийн 1.3.6-д “Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 30 хүүхдээс ихгүй, өдөр өнжүүлэх бүлэг болон 6 настай 1-р ангид хамрагдах хүүхдийн тоог тухайн хот, суурины хүн амын тоо, нягтрал, бүтэц

¹ “Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих”



бүрэлдэхүүнийг үндэслэн зургийн даалгаврын дагуу тогтооно. 6 настай хүүхдийн онцлогоос хамаарч анги дүүргэлтийг 20-24 сурагчтай байхаар тооцох нь зохимжтой.” гэж заасан байна.

Хэрлэн сумын хувьд бүх сургуулиуд хүчин чадлаа бүрэн ашиглаж байна. Хан-Уул цогцолбор сургуулийн анги дүүргэлт 93 хувьтай байгаа нь 2014 онд шинээр сургууль ашиглалтад орсонтой холбоотой байна.

Бусад сумдын сургуулиудын хувьд анги дүүргэлт харилцан адилгүй байна. Анги дүүргэлт 100-аас дээш хувьтай байгаа 8, 46-86 хувьтай 6 сургууль байна.

Хүснэгт 1. “Сургуулиудын хүчин чадлыг сурагчдын тоонд харьцуулсан судалгаа 2019-2020 оны хичээлийн жил”

№	Сургуулийн нэр	Хүчин чадал	Сурагчдын тоо	Хэтрэлтийн хувь
	Хэрлэн сумын төрийн сургуулиуд			
1	1-р сургууль	1280	2038	159
2	2-р сургууль	240	368	153
3	5-р сургууль	1280	1877	146
4	8-р сургууль	1547	1709	110
5	11-р сургууль	350	411	117
6	12-р сургууль	640	1309	204
7	Шинэ хөгжил цогцолбор сургууль	890	1621	182
8	Хан-Уул цогцолбор сургууль	1768	1652	93
9	ДИС-ийн харьяа Ахлах сургууль	150	73	49
	Сумдын сургуулиуд			
10	Баяндун сумын ЕБС	350	587	167
11	Баянтүмэн сумын ЕБС	160	116	72
12	Баян-Уул сумын ЕБС	820	926	112
13	Булган сумын ЕБС	160	138	86
14	Гурванзагал сумын ЕБС	160	169	106
15	Дашбалбар сумын ЕБС	620	610	98
16	Матад сумын ЕБС	320	306	96
17	Сэргэлэн сумын ЕБС	400	185	46
18	Халхгол сумын ЕБС	640	373	58
19	Халхгол сумын Ялалт багийн ЕБС	160	85	53
20	Хөлөнбуйр сумын ЕБС	530	270	51
21	Цагаан-Овоо сумын ЕБС	320	602	188
22	Чойбалсан сумын ЕБС	320	402	126
23	Чулуунхороот сумын ЕБС	320	348	108
	Хэрлэн сумын хувийн сургуулиуд			
24	Flower сургууль	250	315	126
25	Түгээмэл оюун	80	46	57
26	Шинэ зуун	200	69	34
27	Долоодой	240	43	18

Баянтүмэн, Булган, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын хувьд аймгийн төвд ойр байршилтай, шилжилт хөдөлгөөн их байгаа нь анги дүүргэлтэд нөлөөлсөн байна. Халхгол сумын хувьд шинэ сум ашиглалтад орж, сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Хувийн сургуулиудын анги дүүргэлт 18-57 хувьтай байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.3-т “Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг үндэслэн БСШУС-ын сайдын 2019 оны 05 сарын 14-ны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг баталсан байна.



Сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах анги байгаа хэдий ч сургалт явуулах арга зүй дутмаг байгааг БСУГ анхаарч ажиллах шаардлагатай байна.

- *ЕБС-ийн шинээр баригдах барилгын хүчин чадлыг оновчтой тодорхойлоогүй байх /2016-2018/*

Аймгийн хэмжээнд 2016-2018 оны хичээлийн жилд ашиглалтад орсон Халхгол, Баян-Уул сумдын сургуулиуд байна.

Халхгол сумын ЕБС-ийн анги, танхимын зай талбай стандартад нийцэж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд зориулсан шат, бариул, физик, химийн кабинетын арын өрөө зурагт тусгагдаагүй тул хийгдээгүй байна. Сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг чөлөөтэй орж гарах нөхцөл боломж бүрдээгүйгээс сурагчдыг анги танхимд оруулж гаргахад хүндрэлтэй байдаг байна.

Баян-Уул сумын ЕБС-ийн анги, танхимын зай, талбай стандартад нийцэж байгаа боловч 820 /бага, ахлах нийлсэн/ хүүхдийн хүчин чадалтай барилгад 926 хүүхэд суралцаж байгаа нь хүчин чадлыг дутуу төлөвлөсөнтэй холбоотой байна.

Тус сургуулийн барилгын ажил 2012 оны улсын төсөвт тусгагдсан боловч 2015 оноос барилгын ажил царцаагдаж, 2019 оны 02 дугаар сард ашиглалтад орсон байна. Тухайн үед суралцагчдын тоо, хүн амын өсөлтийг дутуу тооцооноос өнөөдөр хүчин чадал хэтрэх хэмжээнд хүрсэн байна.

Нийт хүүхдийн тоо хүчин чадлаас илүү байгаа ч нэг ангид ногдох дундаж хүүхдийн тоо 26,4 буюу нормт хэмжээнд байгаа нь бага, дунд ангиуд 2 ээлжээр хичээллэж байгаатай холбоотой байна.

- *Нэг ангид ногдох хүүхдийн тоо харилцан адилгүй, зохих түвшнээс өндөр байх /байршил, хэв шинж, сургалтын чанараас шалтгаалан/*

Статистик мэдээгээр аймгийн хэмжээнд ЕБС-д хамрагдах 6-17 насны нийт 17763 хүүхэд байгаагаас 16648 хүүхэд сургуульд хамрагдаж, хамран сургалт 93,7 хувьтай байна. /Эх сурвалж: Аймгийн статистик мэдээ 2019, Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны статистик мэдээ/

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тушаалын 1.4-т заасны дагуу “Анги дүүргэлтийг бага ангид 30-35 /багын салбар бүлэгт 20-оос доошгүй/ дунд, ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг дүүргэлтийг 25-30, харах, сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулна.” гэж заасан байна.

Сургуулиудын анги дүүргэлтийг авч үзэхэд Хэрлэн сумын 1, 5 дугаар сургуулиудад нэг ангид ногдох хүүхдийн тоо батлагдсан норм, нормативаас 3-8 хувиар илүү байна.

Хүснэгт 2. “Нэг ангид ногдох дундаж хүүхдийн тоог байршил, хэв шинж, чанарын үзүүлэлтээр харьцуулсан судалгаа 2019-2020 оны хичээлийн жил”

№	Сургуулийн нэр	Хүчин чадал	Сурагчдын тоо	Бүлгийн тоо	1 ангид ногдох дундаж хүүхэд	Норм	Зөрүү
---	----------------	-------------	---------------	-------------	------------------------------	------	-------



Ердийн сургуулиуд /Хүн ам ихээр байршсан/							
1	1-р сургууль	1280	2038	54	37,7	30-35	+2,7
2	5-р сургууль	1280	1877	53	35,4	30-35	+0,4
3	8-р сургууль	1547	1709	50	34,2	30-35	Хэвийн
4	12-р сургууль	640	1309	38	34,4	30-35	Хэвийн
5	Шинэ хөгжил цогцолбор сургууль	890	1621	48	33,8	30-35	Хэвийн
Ердийн сургалттай сургуулиуд /Алслагдсан сургууль/							
6	2-р сургууль	240	368	14	26,2	30-35	-3,8
7	11-р сургууль	350	411	20	20,5	30-35	-9,5
Ердийн сургалттай сумын сургуулиуд							
8	Баяндун сумын ЕБС	350	587	21	28	30-35	-2,7
9	Баянтүмэн сумын ЕБС	160	116	9	12,9	30-35	-17,1
10	Баян-Уул сумын ЕБС	820	926	35	26,5	30-35	-3,5
11	Булган сумын ЕБС	160	138	9	15,3	30-35	-14,7
12	Гурванзагал сумын ЕБС	160	169	9	18,7	30-35	-11,3
13	Дашбалбар сумын ЕБС	620	610	20	30,5	30-35	Хэвийн
14	Матад сумын ЕБС	320	306	11	27,8	30-35	-2,2
15	Сэргэлэн сумын ЕБС	400	185	9	20,5	30-35	-9,5
16	Халхгол сумын ЕБС	640	373	16	23,3	30-35	-6,7
17	Халхгол сумын Ялалт багийн ЕБС	160	85	9	9,4	20	-10,6
18	Хөлөнбуйр сумын ЕБС	530	270	10	27	30-35	-3
19	Цагаан-Овоо сумын ЕБС	320	602	23	26,2	30-35	-3,8
20	Чойбалсан сумын ЕБС	320	402	17	23,6	30-35	-6,4
21	Чулуунхороот сумын ЕБС	320	348	12	29	30-35	-1
Гүнзгийрүүлсэн олон улсын сургалттай сургууль							
22	Хан-Уул цогцолбор сургууль	1768	1652	53	31,2	30-35	Хэвийн
2017-2020 онд ЭЕШ-т байр эзэлсэн сургуулиуд /чанар/							
23	Flower сургууль	250	315	16	19,7	30-35	-10,7
24	Шинэ зуун сургууль	200	69	12	5,7	30-35	-24,3
25	ДИС-ийн харьяа Ахлах сургууль	150	73	3	24,3	25-30	-0,7
Хувийн бусад сургуулиуд							
26	Түгээмэл оюун	80	46	4	11,5	20	-8,5
27	Долоодой	240	43	8	5,4	20	-14,5

Харьцуулалтаас харахад хэв шинж, сургалтын чанарын үзүүлэлтээс илүү хүн амын байршлаас шалтгаалан нэг ангид ногдох хүүхдийн тоо их байгаа нь харагдаж байна.

Тухайлбал 6, 9 дүгээр багийн 1, 5-р сургуулиудын ачаалал нормативаас өндөр, мөн 7-р багийн 8-р сургууль, 4-р багийн 12-р сургууль, 10-р багийн Шинэ хөгжил цогцолбор сургуулиудын хүчин чадал, норм, нормативаас хэтрэх хэмжээнд хүрээд байна.

Цаашид хүн амын тоо жилээс жилд өсөх хандлагатай байгаа учраас сургуулиудын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор зарим сургуулиудыг өргөтгөх, нэмж сургууль барьж байгуулах хэрэгцээ шаардлага үүссээр байна.

А.2.2. Ерөнхий боловсрол олгоход шаардлагатай материаллаг орчин хангалттай бүрдээгүй байна.

- Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, зориулалтын барилга байгууламжгүй байх. Эдийн засгийн үр ашиггүй барилгад жил бүр урсгал засвар хийх /номын сан, спорт заал, Сургуулийн



эзэмшил газарт барилга байгууламж баригдаж сургалтын орчинд сөргөөр нөлөөлсөн байх, стандартын хэрэгжилт өмчийн хэлбэрээс хамааран харилцан адилгүй/

Дорнод аймгийн хэмжээнд нийт 27 ерөнхий боловсролын сургууль байгаагаас түүвэрт хамрагдсан 20 сургуулийн 19 нь зориулалтын, 1 нь зориулалтын бус барилгад үйл ажиллагаа явуулж байна.

Хэрлэн сумын 11 дүгээр сургууль нь анх 1991 онд зориулалтын бус барилгад үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Тус сургуулийн барилгын анхны зориулалт нь хэмжил зүйн газрын оффисын зориулалтаар анх баригдсан боловч урлагийн заал байхгүй, анги танхим нь зай талбай, сургалтын орчны стандарт, нөхцөл байдалд нийцэхгүй байна. Шинэ сургуулийн барилга бариулах тухай зургийг захиалагчаас 2014 онд, төсвийг 2015 оноос 2 удаа хийлгэж, холбогдох газруудад хандсан боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Мөн их болон урсгал засвар хийх шаардлага үүссэн 4 сургууль байна.

Үүнд:

- *Гурванзагал сумын сургууль: МХГ-аас их засварт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлт өгсөн бөгөөд 1974 онд ашиглалтад орсноосоо хойш нэг ч их засварт орж байгаагүй, анги танхим дулаан алдалттай, орчны нөхцөл стандартад нийцэхгүй байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.*
- *Хэрлэн сумын 1-р сургууль: МХГ-ын дүгнэлтээр 2018 онд дээврийн их засвар хийгдсэн. 1969 онд ашиглалтад орсон боловч нэг ч удаа их засварт орж байгаагүй, 2020 оны байдлаар спорт заалны нуруу хотойсон, урд жигүүрийн 00-ын харалдаа цууралт өгч, хагарсан байдалтай байна.*
- *Сэргэлэн сумын сургууль: 1960 онд ашиглалтад орж, МХГ-ын 2013 онд хийгдсэн их засварт оруулах шаардлага үүссэн дүгнэлт гарсан боловч нэг ч удаа их засварт орж байгаагүй.*
- *Баянтүмэн сумын сургууль: 1979 онд ашиглалтад орсноос хойш барилга байгууламжийн ашиглалтын талаар МХГ-ын дүгнэлт гаргуулж байгаагүй, нэг ч удаа их засварт орж байгаагүй.*

Барилгын тухай хуулийн 46.1.14-т “Барилга байгууламжийн ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах”, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг нормд “Хэвийн нөхцөлд ашиглах угсармал том хавтгаалжин, гулдмай, байгалийн чулуу ба тоосгон ханатай, төмөр бетон хучилттай барилга, байгууламжууд”-ын хувьд их засвар хийх хамгийн бага хугацааг 15-20 жил байхаар заасны дагуу дээрх сургуулиуд урсгал болон их засвар хийх шаардлага үүссэн байна.

Их засвар хийгдсэн боловч ашиглагчийн сэтгэл ханамжид нийцээгүй, зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй, “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт”-д хийсэн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангаагүй дараах ажлууд байна. Үүнд:

- *“Баяндун сумын сургуулийн спорт заалны засвар, 110.1 сая төгрөгийн ажил”-ыг “Бүжнэр” ХХК гүйцэтгэж, албан шаардлагын биелэлтийг дутуу хэрэгжүүлсэн байна.*
- *“Дашбалбар сумын сургуулийн барилгын их засвар, 496.6 сая төгрөгийн ажил”-ыг “ЦОДММ” ХХК гүйцэтгэж, албан шаардлагын биелэлтийг дутуу хэрэгжүүлсэн байна. Тус сургуулийн хувьд 1978 онд баригдсан, МХГ-ын улсын байцаагчийн их засварт оруулах тухай дүгнэлттэй. Их засвар 2019 онд хийгдсэнээс хойш дулаан алдалт нь багасаагүй байна. Энэ нь нэг талаас хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө ажлын даалгавар, тоо хэмжээг дутуу боловсруулсан, нөгөө талаас тухайн компанийн зүгээс ажлыг*



эхлэхээс өмнө барилгын байдалтай газар дээр нь очиж танилцаагүй байсантай холбоотой байна.

Шинээр баригдсан боловч ашиглалтын явцад асуудал үүсэж байгаа дараах ажлууд байна. Үүнд:

- Баян-Уул суманд “Сүхжин” ХХК-ийн гүйцэтгэсэн шинэ сургуулийн барилгын ажлыг улсын комисс 2019 оны 02 дугаар сард хүлээн авсан боловч 2020 оны 09 дүгээр сарын байдлаар спорт болон урлагийн заалны дээврээс борооны ус гоожсон, 3 давхрын 00-ын далд шугамаас ус гоожсон байдалтай байна. Компанийн зүгээс холбогдох хүмүүс ирж нөхцөл байдалтай танилцсан гэх боловч одоог хүртэл засагдаагүй байна.
- Халхгол суманд “Шинэ сум” төслийн хүрээнд “Их модун” ХХК-ийн гүйцэтгэсэн шинэ сургуулийн барилгын ажлыг 2019 оны 11 сард улсын комисс хүлээж авсан боловч 2020 оны 04 дүгээр сараас эхлэн спорт заал, зарим анги танхим, коридорын дээврээс борооны ус гоожсон байдалтай байна. Компанийн ажилтнууд нөхцөл байдалтай газар дээр нь танилцахаар ирж, холбогдох арга хэмжээг авсан гэх боловч одоог хүртэл засагдаагүй байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагч болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс барилга, засварын ажлыг хангалтгүй хийсэн компаниудаар зөрчлийг арилгуулах, сонгон шалгаруулалт хийхдээ хүчин чадлыг харгалзах, удаа дараа зөрчил гаргаж байгаа компаниудыг дараагийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

- *Сургуулийн анги танхимыг зориулалтын дагуу ашиглаагүй байх /сургалтын орчин, хими, физик, технологи, гэх мэт зарим хичээлд зориулсан зориулалтын танхим кабинетгүй байх, 6 настай хүүхдийн бие бялдрын хөгжилд таарсан/*

БСШУС-ын 2018 оны А/762 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах нийтлэг журам”-ын 1.2-т “Суралцагчийн сурах хэрэгцээ, сонирхлыг дэмжих, мэдлэг, чадвараа шинэ нөхцөлд хэрэглэх, шинжлэн судлах арга барилд суралцах, сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц орчин бүрдүүлэх зорилгоор кабинет, лаборатори байгуулж ашиглана.”, 2.1-т “Кабинет, лаборатори байгуулах саналыг багш, заах аргын нэгдэл эсхүл сургуулийн захиргаа гаргаж болно.” заасан байна.

Аймгийн хэмжээнд 27 ЕБС-д хүчин чадлын дагуу 511 анги, танхим байгааг 100 хувь сургалтын зориулалтаар ашиглаж байна. Төрөлжүүлэн тохижуулж гэрчилгээ олгосон 129 кабинет, танхим байгаа нь нийт анги, танхимын 25 хувийг эзэлж байна. Эдгээр нь гол төлөв математик, технологи, мэдээлэл зүй, химийн кабинетууд байна. Сургалтын орчныг сайжруулах идэвх санаачилга харилцан адилгүй байгаа бөгөөд огт кабинет байгуулаагүй сургууль ч байна.

Аймгийн хэмжээнд нийт 950 багш, ажиллагсад /захирал, багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан/ байгаагаас аудитын явцад ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар 645 багш, ажиллагсад буюу 68 хувийг хамруулсан.

Цахимаар авсан санал асуулгын “Байгалийн ухааны хичээлийг зориулалтын кабинет лабораторид хичээллүүлдэг үү?” гэсэн асуултад 56,2 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.

Дүрслэл № 1 “Санал асуулгын дүн



Үүнээс харахад оролцогчдын 50-иас дээш хувь нь байгалийн ухааны хичээлүүдийг кабинет, зориулалтын лабораторид хичээллэдэггүй гэж хариулсан нь энэ төрлийн кабинетууд хангалттай хэмжээнд байхгүй байгааг харуулж байна.



Сайн жишээ:

1. Аймгийн Засаг даргын санаачилгаар 2020 онд 6 настны сэтгэхүйн онцлог, хэрэгцээнд тулгуурлан сурч хөгжих ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор сургууль бүрд 1 ангийг жишиг ангиар тохижуулж, “Манай анги” төслийг 158.0 сая төгрөгөөр хэрэгжүүлж байна. Энэ суралцагчийн нас, бие бялдрын хөгжилд тохирсон орчныг бүрдүүлэх ажлын сайн эхлэл болж байна.
2. Аймгийн төвийн сургуулиудаас Хан-Уул цогцолбор сургуулийн технологи, англи хэл, математик, хими, физикийн кабинетууд нь орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан байгаа нь удирдлагын арга барил, зохион байгуулалт сайн байгаатай холбоотой байна.
3. Мөн сумын сургуулиудаас Баяндун сумын сургууль нь технологи, бага ангийн математикийн кабинет нь сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангагдаж, Физик, түүх нийгэм, монгол хэлний кабинет байгуулахаар анги, танхимаа бэлтгэсэн зэрэг нь удирдлагын арга хандлага, идэвх санаачилгатай холбоотой байна.

- *ЕБС-ийн гадаад болон дотоод орчин хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах нөхцөл бололцоо бүрдээгүй байх /ойр орчимд хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа эсэх/*

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7-д “Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.” гэж заасан байна.

“ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS-6782:2019” стандартад зааснаар сургуулиуд нь гадаад, дотоод орчны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх шаардлага үүссэн байна. Аудитын хүрээнд түүвэрт хамрагдсан 20 сургуулиудаас хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд өөрийн байгууллагын гадаад, дотоод эрсдэлийг үнэлж байгаа боловч дээрх стандартын дагуу 50 хувь нь үнэлээгүй байна.

Аймгийн БСУГ-аас сургуулийн гадаад орчны эрсдэлийг үнэлэх судалгаанд 25 сургууль хамрагдаж, эрсдэлийн 29 үзүүлэлтээс бага эрсдэлтэй 20, дунд эрсдэлтэй 7, их эрсдэлтэй 2 үзүүлэлт гарсан байна. Их эрсдэлтэй үзүүлэлт нь замын гарц, тэмдэг, тэмдэглэгээ бүрэн хийгдээгүйгээс зам хөндлөн гарахад үүсдэг эрсдэл байна. Нийт 25 сургуулийн 20 нь буюу нийт сургуулийн 80% нь бага эрсдэлтэй, 5 нь буюу нийт сургуулийн 20% нь дунд эрсдэлтэй гарсан байна.

Харин аудитын түүвэрт хамрагдсан сургуулиудаас гадаад орчны аюулгүй байдлын 5 үзүүлэлтээс 3 нь бүрэн хангагдаагүй, “дунд”-аас “их” эрсдэлтэй гарсан дараах сургуулиуд байна. Үүнд:

Хүснэгт 3. “Гадаад эрсдэлийн судалгаа”

№	Сургуулийн нэр	Камер	Гэрэлтүүлэг	Хашаа, хайс	Замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч
---	----------------	-------	-------------	-------------	--



1	Хэрлэн сумын 2-р сургууль	бага	бага	бага	их
2	Хэрлэн сумын 5-р сургууль	бага	бага	бага	дунд
3	Хэрлэн сумын 8-р сургууль	бага	бага	бага	дунд
4	Хэрлэн сумын 11-р сургууль	бага	бага	дунд	дунд
5	Хан-Уул цогцолбор сургууль	бага	бага	бага	дунд
6	Flower сургууль	бага	бага	бага	дунд
7	Баяндун сумын ЕБС	дунд	бага	бага	их
8	Гурванзагал сумын ЕБС	их	бага	бага	дунд
9	Дашбалбар сумын ЕБС	их	бага	бага	дунд
10	Халхгол сумын ЕБС	их	бага	бага	дунд
11	Чойбалсан сумын ЕБС	их	бага	бага	дунд

Замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч: Судалгаанаас харахад Хэрлэн сумын 2, 5, 8, 11, Хан-Уул цогцолбор сургуулиуд гадаад орчин “дунд”-аас “их” эрсдэлтэй байгаад Чойбалсан хотын 2-р багаас 1-р баг хүртэл тавигдсан авто замын дагуу тэмдэг, тэмдэглэгээ хурд, сааруулагч хийгдээгүй нь нөлөөлсөн байна.

Хувийн Flower сургууль, Баяндун, Гурванзагал, Дашбалбар, Халхгол, Чойбалсан сумдын сургуулийн хувьд замын тэмдэг, тэмдэглэгээ хийлгүүлэх хүсэлтийг аймаг, сумдын удирдлагуудын түвшинд тавьсан боловч шийдвэрлэгдээгүй байна.

Камержуулалт: Баяндун, Гурванзагал, Дашбалбар, Халхгол, Чойбалсан сумын сургуулиуд камержуулалтын хувьд “дунд”-аас “их” эрсдэлтэй байгааг орон нутгийн удирдлагууд анхаарах шаардлагатай байна.

Хашаа, хайс: Хэрлэн сумын 11-р сургуулийн хувьд “дунд” эрсдэлтэй байна.

Сайн жишээ: Сургуулиудын хувьд гэрэлтүүлгийн асуудалд бага эрсдэлтэй гарч байгаа нь аймаг, сумдаас санаачлан “Сургууль, цэцэрлэгийн бүс” төслийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Сургуулийн ойр орчимд хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байгаа дараах асуудлууд байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын 8-р сургуулийн /бага сургуулийн/ эдэлбэр газарт “Чойбалсан констракшн” ХХК-ийн барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тулгаж, хашаажуулсан нь сургуулийн хашааг хойд талаас нь эвдэлж, нураасан байна.
- Ерөнхий боловсролын 2-р сургуулийн ойр орчимд уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаагаас Төмөр замын хорооллоос сургууль руу орж ирдэг явган хүний замыг эвдэлж, гэмтээсэн байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх чиглэлийг өгч ажиллах нь зүйтэй байна.

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн сургалтын хэрэгслэгдэхүүн, тавилга эд хогшил хүрэлцээгүй байх /шинэ сургуулийн хувьд/**

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр сургуулиудад сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1003 ширхэг компьютер, захиргаа, багшийн сургалтад ашиглагдаж буй 924 ширхэг компьютер, 3 ширхэг кодоскоп, 81 ширхэг проектор, 90 ширхэг сканер, 187 ширхэг принтер, 523 ширхэг ангийн самбар, 32 ширхэг ухаалаг самбар, 7716 сурагчийн ширээ, 9703 ширхэг сурагчийн сандал нийлүүлэгдсэн байна. Эдгээр нь сургалтад бүрэн ашиглагдаж байна.

Шинээр 2016-2019 онд ашиглалтад орсон Баян-Уул сургуулийн ЕБС, Халхгол сумын ЕБС-иуд байгаагаас физик, хими, биологийн танхимын хичээлийн хэрэглэгдэхүүн хангагдаагүй, дутмаг байдалтай байна.



- Сургуульд бэлтгэгдсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном сурах бичгийн нийлүүлэлт, ашиглалт хангалтгүй байх /лабораторийн тоног төхөөрөмж, ухаалаг самбар гэх мэт ашиглах боломж нөхцөл бүрдээгүй байх/

УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоол “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 4.2-т “Боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутаг, үндэсний онцлогт суурилсан музей, кино, хэрэглэгдэхүүн, лабораторид түшиглэн үйлийн явцад суралцах боломжийг бүрдүүлэхэд бүх талын оролцоог хангана.”, 4.3-т “Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүн, сургалтын байгууллагын үйлчилгээнд тавих стандарт, шаардлагыг тогтвортой мөрдөн, чанар, үр дүнг тогтмол үнэлж зохицуулалт хийнэ.”, 6.4-т “Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулагчдыг дэмжинэ.” гэж заасан байна.

Гэтэл зарим сургуулийн ширээ сандал, компьютер, техник хэрэгсэл дутмаг, ухаалаг самбар хөдөөгийн зарим сургуулиудад нийлүүлэлт хангалтгүй байна.

Сургуулиудын хувьд нэг компьютерт ногдох хүүхдийн тоо, хэмжээг дүрэм, журмаар зохицуулсан зохицуулалт байхгүй бөгөөд сургалтад ашиглаж буй компьютероор хангагдсан байдал аймаг, суманд харилцан адилгүй байна.

Хүснэгт 4. “Сургалтын компьютерын хангалтын судалгаа”

№	Сургуулийн нэр	Дунд, ахлах ангийн суралцагчийн тоо	Сургалтад ашиглагдаж буй компьютерын тоо	Нэг компьютерт ноогдох хүүхдийн тоо
1	Хэрлэн сумын 1-р сургууль	1407	150	9
2	Хэрлэн сумын 2-р сургууль	281	30	9
3	Хэрлэн сумын 5-р сургууль	1484	134	11
4	Хэрлэн сумын 8-р сургууль	1198	75	16
5	Хэрлэн сумын 11-р сургууль	291	94	3
6	Хэрлэн сумын 12-р сургууль	854	37	23
7	Хан-Уул цогцолбор сургууль	1177	67	17
8	Шинэ хөгжил цогцолбор сургууль	1037	117	9
9	Баяндун сумын ЕБС	443	30	15
10	Баянтүмэн сумын ЕБС	52	11	5
11	Булган сумын ЕБС	60	17	4
12	Гурванзагал сумын ЕБС	93	10	9
13	Дашбалбар сумын ЕБС	403	14	29
14	Матад сумын ЕБС	154	14	11
15	Сэргэлэн сумын ЕБС	108	3	36
16	Халхгол сумын ЕБС	217	37	6
17	Халхгол сумын Ялалт багийн ЕБС	47	9	5
18	Хөлөнбуйр сумын ЕБС	141	18	8
19	Цагаан-Овоо сумын ЕБС	439	27	16
20	Чойбалсан сумын ЕБС	277	16	17
21	Чулуунхороот сумын ЕБС	254	6	42

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2019-2020 оны статистик мэдээ

Тухайлбал: Хэрлэн сумын 8-р сургууль, Хан-Уул, Шинэ хөгжил цогцолбор сургуулиудын дунд, ахлах ангийн суралцагчдын тоо ойролцоо байхад Шинэ хөгжил цогцолбор сургуулийн хувьд 9 хүүхдэд, Хан-Уул цогцолбор сургуулийн хувьд 17 хүүхдэд, 8-р сургуулийн хувьд 16 хүүхдэд 1 компьютер байна.

Мөн бусад сумдын сургуулиудын хувьд Баяндун суманд 15, Дашбалбар суманд 29, Сэргэлэн суманд 36, Цагаан-Овоо суманд 16, Чойбалсан суманд 17, Чулуунхороот суманд 42 сурагчийн дунд 1 компьютер ашиглаж байна.



Сургалтыг зайнаас, цахимаар зохион байгуулахад шаардлагатай ухаалаг самбар Баян-Уул, Халхгол сумын сургуулиудад огт нийлүүлэгдээгүй байна.

Мөн аудитын явцад Хэрлэн сумын 1-р сургууль, Булган, Гурванзагал, Хөлөнбуйр, Халхгол сумдын сургуулиуд ширээ, сандлын нийлүүлэлт дутагдалтай байгаа нь ажиглагдсан.

Дүрслэл 2. “Ном, сурах бичгийн хүрэлцээ”



Ном сурах бичиг:

Санал асуулгаар “Танай сургуулийн сурагчдад сурах бичгийн хүрэлцээ хангалттай эсэх” гэсэн асуултад 54 хувь нь “Үгүй, зарим хичээлийн сурах бичиг хангалтгүй” гэж хариулсан нь хичээл, сургалтад ашиглагдаж буй ном, сурах бичгүүд нь сурагчдад бүрэн хүрэлцдэггүй, дутмаг байгааг харуулж байна.

Иймд сургуулиудын сургалтад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж болон бусад хэрэглэгдэхүүнүүдийн тэгш, хүртээмжтэй нийлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

А.2.3 Аймгийн хэмжээнд зарим мэргэжлийн багш нар дутагдалтай байна.


- Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй байх /багш, нийгмийн ажилтан, номын санч, багш мэргэжлээрээ ажиллаагүй байх/

Дорнод аймагт 2019 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар нийт 27 ерөнхий боловсролын сургуульд 27 захирал, 45 сургалтын менежер, 850 багш ажиллаж байна.

Дүрслэл 3. “Багш, ажилтнуудын тоо”



Дүрслэл 4. “Багш нарын боловсрол түвшин”



Аймгийн хэмжээнд биологи, хими, байгалийн ухаан, дуу хөгжим, технологи, бага ангийн багш болон эмчийн орон тоо дутагдалтай байна.




Хүснэгт 5. “Багшийн хэрэгцээний судалгаа /сургууль бүрээр/”

№	Сургуулийн нэр	Хими, биологи, байгалийн ухаан	Түүх, нийгэм	Математик	Бага анги	Дуу хөгжим	Зураг, технологи	Физик	Мэдээлэл зүй	Эмч	Сургалтын менежер	Бүгд
	Баян-Уул ЕБС	1	1				1					3
1	Баяндун ЕБС	1		1	1							3
2	Баянтүмэн ЕБС					1						1
3	Гурванзагал ЕБС	1				1						2
4	Дашбалбар ЕБС				2	1						3
5	Матад ЕБС	1				1						2
6	Сэргэлэн ЕБС					1	1					2
7	Халхгол ЕБС				1						1	2
8	Хөлөнбуйр ЕБС	1		1	1							3
9	Цагаан-Овоо ЕБС						1					1
10	Чойбалсан ЕБС					1						1
11	Халхгол Ялалт баг ЕБС					1	1					2
12	Шинэ хөгжил ЦС	1								1		2
13	1-р сургууль	1			1	1						3
14	8-р сургууль	1						1		1		3
15	12-р сургууль	2										2
16	Flower сургууль									1	1	2
17	Дорнод ахлах сургууль						1	1	1			3
	БҮГД	10	1	2	6	8	5	2	1	3	2	40

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2020-2021 оны статистик мэдээ, сургуулиудаас авсан ярилцлагын тэмдэглэл

Дээрх судалгаанаас харахад аймгийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд 40 багш дутагдалтай байгаа бөгөөд мэргэжлээр нь авч үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 5. “Дутагдалтай мэргэжил”



ЕБС-д ажиллаж байгаа багш, ажилтнууд нь мэргэжлийн байх гэсэн шаардлагад бүрэн нийцсэн байна.

- Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг эсэх

Аймгийн ИТХ-аас багшийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд “Эрдэм хөтөлбөр”, “Багш хөгжлийн төв” шинээр байгуулах төслийг тус тус хэрэгжүүлсэн байна. Эрдэм хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд Орон нутгийн төвлөрсөн 8 сургалт, ажлын байрны 154 удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургууль багш нар 100 хувь хамрагдсан байна. Багш нарын сайн туршлага, үйл ажиллагааг



Улаанбаатар хотын 9 дүүрэг, 6 аймгийн нийт 1100 багш, удирдах ажилтанд түгээн дэлгэрүүлсэн байна.

Багш нарын дотоодын болон гадаад улс, оронд туршлага судлах арга хэмжээ, хөдөө сумдад ажиллаж байгаа багш нарын орон сууцны дэмжлэг, элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдаа 800 оноо авахад бэлдсэн багш нарын урамшуулал, сургалт, семинар, зөвлөгөөнд оролцоход зориулсан дэмжлэг, тусламж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн сургуулиудын урамшуулал зэрэг арга хэмжээнүүдэд аймаг, сумын төсвөөс санхүүжүүлж, урамшуулсан байна.

- *Сургуулийн захирал, эрхлэгч, менежер, багш холбогдох шалгуурт нийцээгүй байх /Багш багшлах эрхгүй байх/*

Төрийн өмчийн сургуулийн захирлуудаас боловсролын хувьд 13 нь магистр, 10 нь бакалавр зэрэгтэй байгаа бөгөөд мэргэжлийн хувьд 1 нь зөвлөх, 7 нь тэргүүлэх, 11 нь заах аргач/ахлах зэрэгтэй байна.

БШУС-ын 2020 оны Б/03 дугаар тушаалаар ЕБС-ийн зарим албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэн байна.

Шинэчлэгдсэн тодорхойлолтод “Суралцагчдын тооноос хамаарч ерөнхий боловсролын сургуульд 3, 5, 6, 8-аас доошгүй жил багшилсан, заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй, 1, 2, 3, 4-өөс доошгүй жил заах аргын нэгдлийн ахлагч, эсвэл сургалтын менежер, удирдах ажил эрхэлсэн туршлагатай байх” гэсэн шаардлага нэмэгдсэнийг 10 захирал буюу 43 хувь нь хангахгүй байна.

Энэ нь тухайн захирлуудыг томилоход БШУС-ын 2007 оны 351 дүгээр тушаалаар батлагдсан ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт мөрдөгдөж байсантай холбоотой байна.

Иймд 2020 оны шинэчлэлтээр нэмэгдсэн мэргэжлийн зэргийн болон бусад шалгуурт нийцүүлэн туршлагаа ахиулах шаардлага үүссэн байна.

- *Салбарын яам ЕБС-ийн хүний нөөцийн бодлого оновчгүй, бодлогын хэрэгжилт үр дүнгүй байх /тэгш хүрэлцээ/*
Орон нутагт хамааралгүй.

А.3. Сургуулиудын төсвийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

А.3.1 Төсвийн төлөвлөлтөд баримталж буй норм, норматив бодит нөхцөлд нийцэхгүй, аргачлал дутмаг байгаагаас хуваарилалт тэгш хүртээмжтэй хийгдэхгүй байна.

- *Төрөөс сургуулиудад олгож буй хувьсах зардлыг онцлог, хэв шинжтэй уялдуулан бодитой төлөвлөж байна уу?*

Боловсролын тухай хуулийн 40.3-д “Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.” гэж заажээ.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн”-ийг цалин, НДШ, бусад



хувьсах гэсэн зардлын ангилалтай байхаар тусгаж, 3 дугаар хавсралтад “нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ыг байршлын хувьд нийслэл, аймгийн төв, аймгийн төвөөс бусад сумдад бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох сургуулиудын хувьд ялгаатай байхаар тогтоосон байна.

Боловсролын тухай хуульд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно гэж заасан ч аудитын хамрах хүрээний 2017-2019 онд жил бүр шинэчлэн тогтоосон итгэлцүүр байхгүй байна. Одоогийн байдлаар 2016 онд тогтоосон нормативыг баримтлан тооцож байна.

Мөн Боловсролын тухай хуулийн 40.5-д “Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын онцлог болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан энэ хуулийн 40.3-д заасан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан боловч эдгээр үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн, ялгавартайгаар баталсан салбарын сайдын аргачлал байхгүй байна.

Аймгийн хэмжээнд улсын хэвшлийн ЕБС-иуд цалингийн хувьсах зардлыг төлөвлөхдөө ЗГ-ын тогтоолоор баталсан нормативыг баримтлаагүй байгаа бөгөөд орон тооны хязгаарт багтаан цалинтай холбоотой бусад журам, заавар, аргачлалыг үндэслэн төлөвлөж байна. Энэ нь уг нормативаар тооцсон цалингийн зардал бодит гүйцэтгэлд хүрэхгүй байгаатай холбоотой байна. Үүнд цалингийн шатлал, зэрэглэл 2017-2019 онуудад нэмэгдсэн, мөн хувьсах зардлын өсөн нэмэгдэх итгэлцүүрийг шинэчлэхгүй байгаа нь нөлөөлсөн байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын бусад хувьсах зардлын төлөвлөлт нийтлэг байдлаар хийгдсэн байна. Нийт бусад хувьсах зардлыг хүүхдийн тооноос хамааруулж ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолд заасан нормативаар тооцсон байна. Бусад хувьсах зардлын бүрэлдэхүүнд тооцогдох 10 төрлийн зардлыг тооцохдоо нийт дүнд эзлэх хувь хэмжээг дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

- I. Бичиг хэргийн зардлыг 8 хувиар,
- II. Шуудан холбооны зардлыг 5 хувиар,
- III. Ном, хэвлэлийн зардлыг 4 хувиар,
- IV. Томилолтын зардлыг 4 хувиар,
- V. Хичээл практикийн зардлыг 35 хувиар,
- VI. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 5 хувиар,
- VII. Эм, вакцины зардлыг 1 хувиар,
- VIII. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг 32 хувиар,
- IX. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 3 хувиар,
- X. Хог хаягдлын зардлыг 3 хувиар тус тус бусад хувьсах зардлаас тооцож байна.

Дээрх аргачлалыг заавал мөрдөхөөр баталсан эрх зүйн акт байхгүй бөгөөд 2015 онд хэвлэгдсэн “Байгууллагын төсөв санхүүгийн төлөвлөлт, удирдлагын арга зүй” гэсэн номд жишээ болгосон аргачлалыг ашигласан байна. Энэ нь бусад хувьсах зардлын бүрэлдэхүүнийг тооцох нэгдсэн аргачлал байхгүй байгаатай холбоотой байна.


Аудитын түүвэрт хамрагдсан улсын хэвшлийн болон хувийн хэвшлийн ЕБС-иудын хувьд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг төлөвлөхдөө хүүхдийн тоог бодит гүйцэтгэлд уялдуулан, мөрдөгдөж байгаа эрх зүйн актын хэмжээнд үндэслэлтэй хийсэн байна.



Төсвийг батлахдаа төсвийн төсөлд тусгасан дүнгээс зөрүүтэй ирүүлсэн байна. Тухайлбал,

/мянган төгрөг/

Дүрслэл №6 “Нийт хувьсах зардал”



Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэхэд хувьсах зардлыг бодитой төлөвлөхгүй байгаа бөгөөд ЗГ-ын тогтоолоор баталсан зардлын нормативт өөрчлөлт хийгдээгүй, байршлын хувьд нийслэл, аймгийн төв, аймгийн төвөөс бусад сумдад ангилал өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй байна.

Тухайлбал: Аймгийн төвийн гэсэн ангилалд байгаа Төв аймаг болон алслагдсан Дорнод аймгийн, мөн сум гэсэн ангилалд байгаа аймгийн төвөөс 50 км зайтай Булган сум, 330 км зайтай байгаа Халхгол сумдын сургуулиудын хувьсах зардлын норматив адилхан байна. Мөн хувийн хэвшлийн төлбөргүй болон 5.0 сая төгрөг хүртэлх төлбөртэй сургуулиудын хувьсах зардлын норматив адил байгаа нь орон нутгийн хүүхдийн тоо, төлбөрийн хэмжээ, бага сургуулиудын нөхцөл байдалд тохирохгүй байна.

- **Төсвийн хуваарилалт оновчтой, тэгш хүртээмжтэй байна уу?**

Сургуулиудын төсвийг Төсвийн тухай хуулийн засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай 61.2 дахь заалтад “энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ.” гэсний дагуу ЕБС-дын төсөв нь аймгийн Засаг даргын төсвийн бүрэлдэхүүнд орж ИТХ-аар батлагдаж байна.

Төсвийн тухай 15.2 дахь “Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга нь ЕБС-иудын хувьд төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байсан байна. Төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөвт зохицуулалт хийх эрхтэй бөгөөд харин уг эрхээ шилжүүлж болох талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Сумдын Засаг дарга нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийг аймгаас олгосон дүнгээр хуваарилан сумын ИТХ-аар батлуулж, сар бүрийн



санхүүжилтийг олгож байгаа ч Төсвийн тухай хуульд зааснаар аймгийн Засаг дарга тухайн байгууллагын төсөвт зохицуулалт хийх эрхтэй байна.

Харин сумын Засаг дарга нар хуулиар олгогдоогүй эрхийг эдэлж Хэрлэн сумын Засаг дарга 2017-2019 онуудад 1-4 удаа, бусад сумдын хувьд Засаг дарга нар 1-2 удаа сургуулиудын төсөвт зохицуулалт хийсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан зарим сургуулиудын бараа үйлчилгээний бусад хувьсах зардлын төсвийн төсөл, анх батлагдсан төсөв болон зохицуулалт хийсэн төсвийг дараах хүснэгтэд үзүүлэв.

/мянган төгрөгөөр/

Хүснэгт №6 “Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал”

Сургуулийн нэр	Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал					
	2017 он		2018 он		2019 он	
	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Анх батлагдсан	Тодотгосон төсөв
1-р сургууль	29271,6	27888,6	21814,7	21814,7	26082,3	29589,1
2-р сургууль	5717,3	18143,9	17074,7	17091,1	8457,3	12727,3
8-р сургууль	21169,3	38367,9	29994,2	32705,4	22141,8	26385,8
11-р сургууль	6868,9	16987,5	8229,0	8229,0	7784,0	9872,6
12-р сургууль	17402,4	35476,6	10691,5	10871,5	16510,2	18560,2
Хан-Уул	30110,0	49446,0	47868,4	52868,4	59612,5	65898,2
Шинэ хөгжил	18248,3	33866,2	21900,0	22795,2	24085,6	29110,4
Булган ЕБС	3759,9	3380,2	3670,6	4397,3	12232,5	16636,8
Чойбалсан ЕБС	9661,1	10029,8	4916,8	5009,7	8438,1	8438,1

Зохицуулалт бүх сургуулийн төсөвт, жил бүр, тогтмол зардлаас хувьсах зардалд, хувьсах зардлын ангилал хооронд шилжүүлэх байдлаар хийгдэж байгаа нь хуваарилалт оновчтой бус байгааг харуулж байна.

Мөн сургуулиудын хувьсах зардлын бүрэлдэхүүнд байхгүй, хуваарилалт нь хүүхдийн тооноос хамаарахгүй зардлын төсвийн хувьд аймгийн төвөөс хамгийн хол буюу 330 км-д байршилтай Халхгол сумын 9 жилийн сургуульд хуваарилсан тээвэр шатахуун, урсгал засварын зардлууд аймгийн төвөөс хамгийн ойр 50 км-ийн зайд байршилтай Булган сумын 9 жилийн сургуульд хуваарилсан тухайн зардлуудаас бага байна. Дүрслэл 7

/мянган төгрөг/

Дүрслэл №7 “Төсвийн хуваарилалт”





Тээвэр шатахууны зардлын хувьд 2018 онд Халхгол сумын 9 жилийн сургуулийнх их байгаа нь тус зардалд нүүрсний тээврийн ажлын хөлс багтсантай холбоотой байна. Хүүхдийн тооноос хамаарч хуваарилагдах бусад хувьсах зардлын төсвийн хуваарилалтыг аймгийн төвд байршилтай ЕБС-иудын хувьд үзэхэд 1652 суралцагчидтай Хан-Уул цогцолбор сургуулийн бусад хувьсах зардлын төсөв, аймгийн хэмжээнд хамгийн олон буюу 2038 суралцагчидтай 1 дүгээр сургуулийн төсвөөс 2018, 2019 онуудад 2 дахин илүү байна. Хүснэгт 7

/мянган төгрөгөөр/

Хүснэгт №7 “Харьцуулсан бараа үйлчилгээний бусад зардал”

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал	2017 он			2018 он			2019 он		
	Хан-Уул сургууль	1-р сургууль	Зөрүү /+-/	Хан-Уул сургууль	1-р сургууль	Зөрүү /+-/	Хан-Уул сургууль	1-р сургууль	Зөрүү /+-/
Бичиг хэрэг	2194,4	1241,3	953,1	3999,4	1300,0	2699,4	5451,8	2523,4	2928,4
Шуудан холбоо	2058,4	1654,7	403,7	3530,0	1714,7	1815,3	4860,0	1329,1	3530,9
Ном, хэвлэл	2207,0	430,5	1776,5	4203,0	800,0	3403,0	2407,2	1113,3	1293,9
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	7016,0	6657,1	358,9	13300,0	3500,0	9800,0	7610,0	9366,4	-1756,4
Хог хаягдал	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	1000,0	756,9	243,1
Эм бэлдмэл	1536,6	600,0	936,6	1536,6	800,0	736,6	2500,0	800,0	1700,0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9568,1	2760,0	6808,1	6068,1	1500,0	4568,1	11256,1	800,0	10456,1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4111,3	1145,6	2965,7	4111,3	1380,0	2731,3	4978,0	1180,0	3798,0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20012,0	12999,4	7012,6	15000,0	10000,0	5000,0	21500,1	11300,0	10200,1
Томилолт	742,2	400,0	342,2	1120,0	1000,0	120,0	4335,0	600,0	3735,0
Дүн	49446,0	27888,6	21557,4	52868,4	21994,7	30873,7	65898,2	29769,1	36129,1

Дээрх хүснэгтээс үзэхэд Хан-Уул цогцолбор сургуулийн бусад хувьсах зардлын хуваарилсан дүн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн батлагдсан дүнгээс Харин Хэрлэн сумын 12 дугаар сургууль нь 2018 оны төсвийн төсөлд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 790.7 мянган төгрөгөөр тусгасан боловч огт батлагдаагүй байна.

Иймд төсвийг тэгш, хүртээмжтэй хуваарилахад анхаарах шаардлагатай байна.

- *Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн үү?*

ЗГ-ын “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 2012 оны 106 дугаар тогтоолын 3-т “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасан.

Сургуулиуд 2017-2019 онд дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг дотуур байранд амьдрах хүүхдүүдийн тооноос хамааруулан дээрх тогтоолд заагдсан нормативаар тооцон төлөвлөдөг байна.

Аудитын явцад түүвэрт хамрагдсан дотуур байртай ЕБС-иудын хүүхдийн хоолны зардлын төсвийн төлөвлөлтийг үзэхэд дотуур байранд амьдрах хүүхдийн тоог бодит гүйцэтгэлтэй уялдуулан, нормативын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна.



- Ном, сурах бичигт шаардлагатай хөрөнгийг бодитой тооцож төлөвлөсөн үү?
- Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсөв бодитой төлөвлөж байна уу? /нас, онцлогт тохирсон, хүрэлцээтэй эсэх/
- Ном, сурах бичгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?
- Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж буй хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулж байна уу?


Ном, хэвлэлийн зардлын төсвийг төлөвлөхдөө Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад заасан бусад хувьсах зардлын 4 хувиар тооцон төлөвлөж, хэрэгцээний талаар судалгаа хийхгүй байна. Хуваарилагдсан зардал нь сурах бичгээс бусад шаардлагатай гарын авлага, хэвлэл захиалгад хүрэлцдэггүй байна.

Сургуулиуд нь шаардлагатай ном, хэвлэлийг батлагдсан зардлын төсөв болон хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төсвөөс авсан байгаа бөгөөд мөн салбарын яам болон бусад эх үүсвэрээс ирсэн дэмжлэгээр тодорхой хувийг шинэчилсэн байна.

Сурах бичгийн зардлын төсвийг төлөвлөдөггүй бөгөөд энэ нь хэрэгцээт сурах бичгийг салбар яамнаас үнэ төлбөргүй нийлүүлдэгтэй холбоотой байна.

Аудитын явцад санал асуулгад хамрагдсан багш, ажилтнуудын 50.0 хувь нь зарим үед багш хувиасаа хэрэглэгдэхүүн авдаг гэж хариулсан байна.

Дүрслэл №8 “Санал асуулгын дүн”



Иймд ном, сурах бичиг бусад хэрэглэгдэхүүний төсвийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөхөд анхаарах шаардлагатай байна.

Дорнод аймгийн төвийн сургуулиудын хувьд 2017-2019 онд дунджаар төсвийн гүйцэтгэлээр 200.0-4200.0 мянган төгрөг, бусад сумдын хувьд 100.0-550.0 мянган төгрөгийг ном, хэвлэлийн зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сургуулиуд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас багшийн хөгжлийг дэмжихтэй холбоотой үйл ажиллагаанд хөрөнгө гарган зарцуулж байна.



Үүнд сургалтад хамруулах, зарим уралдаан тэмцээн, олимпиад арга хэмжээнд өөрөө болон сурагчдыг авч явах томилолт, тээврийн зардал, мөн мэргэжлийн холбогдолтой өндөр үнэтэй ном авах зэрэгт дэмжлэг үзүүлсэн байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хэрлэн сумын 1 дүгээр сургууль нь 2018 онд тус зардлаас 1450.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө /зөөврийн компьютер/-ийг захиргаа аж ахуйн хэрэгцээнд авсан байна.
- Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь 2018 онд тус зардлаас урсгал засварын материал худалдан авахад 1323.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Шинэ хөгжил цогцолбор сургууль нь 2018 онд тус зардлаас урсгал засварын материал худалдан авахад 675.0 мянган төгрөгийг, захиргаа аж ахуйн хэрэгцээнд үндсэн хөрөнгө /зөөврийн компьютер/ худалдан авахад 2000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

А.3.2 Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил гарсаар байна.

- Санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, цаг тухайд нь бүрэн олгоогүй байх.
- Төрийн сан, боловсролын газраас хувьсах зардал олголтод үр нөлөөтэй хяналт тавьж санхүүжүүлдэг үү?

ЗГ-ын 2016 оны 242-р тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 3.12, 4.5-д сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгож байхаар заажээ.

Дорнод аймгийн БСУГ нь дээрх заалтын дагуу сар бүр хүүхэд өдрийн гүйцэтгэлийг хянахгүй байгаа бөгөөд уг асуудалд БСУГ-ын төсвийн мэргэжилтэн “Сар бүр нормативт зардлыг хянадаг боловч төсвийн хуваарийг өөрчлөх боломжгүй байдаг. Учир нь төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлж, аймаг, сумын ИТХ-ын шийдвэрээр зохицуулалт хийгдэнэ. Санхүүжилтийг сумдын төрийн сангаас олгодог. Бид Сангийн яаманд хуваарьт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байсан боловч тухай бүр шийдэгдэж байгаагүй.” гэсэн тайлбарыг өгсөн.

Хэрлэн сумын төрийн сан нь гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, сумын ИТХ-аар төсөвт зохицуулалт хийсэн ч дээд шатны төсөв захирагчаас хууль, тогтоомжийн дагуу зөвшөөрөл аваагүй байгаа бөгөөд Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалд зааснаар гүйцэтгэлийг хянах эрх нь Хэрлэн сумын ЗДТГ-ын нэгжид байхгүй байна.

Сургуулиудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт аймгийн БСУГ-аар дамжин хийгдэж, харин санхүүжилт өөр нэгжээр дамжин олгогддог байдал хяналтад нөлөөлж байгаа хэдий ч төрийн байгууллагуудын ажлын уялдаа, зохион байгуулалт мөн хангалтгүй байна.

Иймд сургуулиудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хяналтыг зохицуулж байгаа эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

- Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож олгодог уу?



“Үдийн цай” хөтөлбөрийг Улсын Их хурлын 2006 оны 66 дугаар тогтоол, ЗГ-ын мөн оны 194 дүгээр тогтоолын дагуу төрийн болон төрийн бус өмчийн 1, 2 дугаар ангид суралцаж байгаа хүүхдүүдээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 600 төгрөгөөр тооцон төлөвлөдөг байна.

Сургуулиудад “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төрийн сангийн нэгжүүд нь хүүхэд өдрөөр тооцож олгохгүй, тухайн байгууллагын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу олгодог байна.

Аудитын явцад сургуулиудын үдийн цай болон дотуур байрны хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхдийн ирцийн бүртгэлтэй тулгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хан-Уул цогцолбор сургууль нь 2019 онд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 1,111.2 мянган төгрөгөөр илүү зарцуулсан,
- Баяндун сумын сургууль нь 2019 онд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 3,815.1 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, ЗГ-ын “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 2012 оны 106 дугаар тогтоолын 1 дэх заалттай нийцэхгүй байна.

- *Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт зориулалтын дагуу зарцуулагдсан уу?*

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” МОН-3243 төслийн хүрээнд 2018, 2019 онд 331.5 сая төгрөгийн өртөг бүхий 247 нэр төрлийн 1585 ширхэг хичээлийн хэрэглэгдэхүүн ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлэгдсэн байна.

“Дэлхийн зөн” ОУ-ын байгууллага, Мобиком корпорацитай хамтран Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдын сургуулиудад 120.0 сая төгрөгийн санхүүжилтээр ариун цэврийн байгууламж, барьж байгуулсан байна.

Төсөл хөтөлбөрийн санхүүжилтүүд зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

- *Сургууль хөгжүүлэх санг үр ашигтайгаар ашиглах нөхцөл бүрдсэн үү?*

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.11-д “Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу БСШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалаар батлагдсан “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”-д дотоод, гадаадын хандивлагч болон тусламж үзүүлэгчээс тухайн байгууллагын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгахаар зохицуулагдсан байна.

Дээрх дүрэмд сургууль хөгжүүлэх сангийн эрх зүйн харилцааг зохицуулсан боловч Дорнод аймагт сургууль хөгжүүлэх сантай сургууль байхгүй байна.



БҮЛЭГ Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД БАЙНА.

Б.1 Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч суурь боловсролын чанар хангалтгүй дүгнэгдсэн байна.

- *Эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг бүрэн олгож байна уу? /улсын, хувийн, лаборатори сургуулиудын сургалтын чанар ялгаатай байх/*


Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны А/491, 492 тоот тушаалуудаар батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг өмчийн хэлбэр үл харгалзан нийт сургуулиуд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн БСУГ-аас хичээлийн жилийн эхэнд сурагчдаас сонгох шалгалтын саналыг авч, хичээлийн жилийн туршид гарааны үнэлгээ, явцын үнэлгээ, сунгаа шалгалтыг авч, сурагчдын ахиц амжилт, өсөлт бууралтыг гарган, хувь сурагч, багш, анги хамт олон, аймгийн хэмжээнд анализ хийн, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажилласан байна.

Ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй эзэмшүүлж байгаа эсэхийг улсын хэмжээнд хийгддэг боловсролын чанарын үнэлгээ болон элсэлтийн ерөнхий шалгалтын дүнтэй харьцууллаа.

1. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр Дорнод аймаг 2016 онд 2 дугаар байр, 2017, 2018 онуудад эхний байр, 2019 онд 6 дугаар байр, 2020 онд 5 дугаар байранд шалгарч сүүлийн 7 жилээр авч үзэхэд эхний 6-д жагссан байгаа нь улсын дунджаас тогтмол дээгүүр үзүүлэлттэй байна.

Дүрслэл №9 “Аймгуудын дундажтай харьцуулсан үнэлгээ”



Энэ нь нийт сургалтын хөтөлбөрийн үр дүнг харуулахгүй ч тухайн суралцагчийн сонгон судалсан хичээлийн чанарын үнэлгээг харуулсан үзүүлэлт юм.



Хүснэгт №8 “Дорнод аймгийн ЕБС-ийн элсэлтийн ерөнхий
шалгалтын сүүлийн 4 жилийн байр эзэлсэн дүн”

№	Сургуулийн нэр	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Хэрлэн сумын FLOWER 12 жилийн сургууль	646.2	626.9		626.6
2	Хэрлэн сумын Шинэ зуун 12 жилийн сургууль	600.9	628.0		
3	Хэрлэн сумын Дорнод ахлах сургууль		583.9	562.7	612.0
4	Хэрлэн сумын Долоодой сургууль				586.9
5	Хэрлэн сумын 8-р сургууль	568.6	571.9	559.8	569.8
6	Хэрлэн сумын 12-р сургууль	554.5	546.4	497.5	574.8
7	Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургууль	544.3	585.7	525.6	531.2
8	Хэрлэн сумын 1-р сургууль	538.6	549.7	474.0	557.4
9	Хэрлэн сумын 5-р сургууль	521.8	535.2	562.2	525.6
10	Хэрлэн сумын Шинэ хөгжил цогцолбор сургууль	563.6	541.4	481.0	501.7
11	Баяндун сумын 12 жилийн сургууль	497.2	527.3	509.1	557.7
12	Баян-Уул сумын 12 жилийн сургууль	513.0	492.7	477.0	498.9
13	Хэрлэн сумын 2-р сургууль	512.5	531.5		494.2
14	Цагаан-Овоо сумын 12 жилийн сургууль	459.4	505.7	481.8	498.6
15	Чулуунхороот сумын 12 жилийн сургууль	483.7	490.1	474.9	536.5
16	Хэрлэн сумын 11-р сургууль	507.7	529.2	504.4	488.6
17	Чойбалсан сумын 12 жилийн сургууль	511.0	479.0		482.6
18	Дашбалбар сумын 12 жилийн сургууль	482.4	501.4	448.9	475.5
19	Халхгол сумын 12 жилийн сургууль	427.0	445.4		466.2

Аймгийн хэмжээнд дээрх үзүүлэлтийг сургууль бүрээр харуулахад сүүлийн 4 жилийн дунджаар нийт сургуулийн 58.0 хувь нь үнэлгээг тогтмол хадгалсан буюу ахиулсан үзүүлэлттэй байна.

Эдгээр үнэлгээг улсын дундажтай харьцуулахад 2017 онд 5, 2018 онд 5, 2019 онд 7, 2020 онд 8 сургууль доогуур үнэлгээтэй байна.


2. Аймгийн хэмжээнд Боловсролын үнэлгээний төвөөс 2017, 2018 онуудад 3 сургууль, 2019 онд 22 сургуулийг боловсролын чанарын үнэлгээнд хамруулсан байна.

Боловсролын үнэлгээний төв нь чанарын үнэлгээг хийхдээ сургуулиудын байршил, хэв шинж, хүйсээр нь ангилан харьцуулалт хийх, мөн сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг судлан шинжилгээ хийдэг байна.



Дорнод аймгийн хэмжээнд 2017, 2018 онуудад 3 сургууль сонгож 5, 9, 12 дугаар ангийн суралцагчдаас 3-9 хичээл, 2019 онд бүх сургуулийн 9 дүгээр ангийн суралцагчдаас 4 хичээлээр шалгалт авсан бөгөөд аймгийн үзүүлэлтийг улсын дундажтай харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл №10 “Улсын дундажтай харьцуулсан үнэлгээ”



Дорнод аймаг нь 2017-2019 онд нийт хичээлийн дундаж үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа нь сонгон судлах хичээлд түлхүү анхаарч, бүх суралцагсдад, заавал эзэмших суурь боловсролыг жигд олгоход анхаарч ажиллаагүйг харуулж байна.

Дорнод аймгийн хэмжээнд БҮТ-өөс 2019 онд хийсэн чанарын үнэлгээнд хамрагдсан бүх сургуулийн 9 дүгээр ангид суралцагсдын үнэлэгдсэн байдлыг авч үзлээ.

Хүснэгт №9 “Чанарын үнэлгээ – суурь боловсрол 2019”

№	Сургууль	Математик		Монгол хэл		Физик		Англи хэл		Дундаж дүн
		Гүйцэтгэлийн дундаж	Байр	Гүйцэтгэлийн дундаж	Байр	Гүйцэтгэлийн дундаж	Байр	Гүйцэтгэлийн дундаж	Байр	
1	I	38.6	6	68.1	1	27.3	3	8.2	18	7
2	II	17.4	20	32.7	20	24.6	9	14.5	13	16
3	V	39.2	5	64.4	2	25.8	5	8.3	17	7
4	VIII	36.2	8	54.5	6	27	4	9	16	9
5	XI	23.4	17	49.4	12	24.2	10	3.1	21	15
6	Цагаан-Овоо	30.7	11	46.8	16	21	18	19.2	5	13
7	XII	31.4	9	54	8	18.9	21	5.8	19	14
8	Хан-Уул	31.4	10	59.6	4	23.9	11	20.7	4	7
9	Шинэ хөгжил	26.8	14	42.6	19	20.8	20	3.9	20	18
10	Баяндун	20.6	19	51.2	10	25.5	7	17.5	8	11
11	Баян-Уул	38	7	46.3	17	23.5	12	16.8	9	11
12	Баянтүмэн	29.8	12	47.8	14	22.8	14	15.8	11	13
13	Булган	26.3	15	56.3	5	20.8	19	31.3	2	10
14	Гурванзагал			54.4	7	25.6	6	18	7	7



Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн

15	Дашбалбар	39.7	4	47.3	15	23.3	13	19.1	6	10
16	Матад	22.4	18	27.4	21	18.6	22	9	16	19
17	Сэргэлэн	40.2	3	43.2	18	25.1	8	13.6	14	11
18	Халхгол	27.8	13	48	13	21.1	17	16.7	10	13
19	Хөлөнбуйр	40.9	2	52.9	9	27.7	2	22.4	3	4
20	Чойбалсан	25.5	16	32.7	20	22.7	15	9.6	15	17
21	Чулуунхороот	5	21	51	11	21.3	16	33.4	1	12
22	Flower	63.8	1	59.7	3	38.9	1	14.7	12	4
Аймаг		33.4		54		24.2		12.3		
Зүүн бүс		29.9		51.3		24		19.5		
Улсын хэмжээнд		34.8		50.5		26.1		26.3		
Шалгуулагчдын тоо		1072		1123		570		552		

Дорнод аймгийн хэмжээнд 2019 онд 22 сургуулийн суурь боловсрол буюу 9 дүгээр ангийн сурагчдын сургалтын чанарын үнэлгээний дүнгээс харахад эхний 7 байранд хувийн сургууль 1, лаборатори сургууль 1, ердийн хэв шинжит 5 сургууль өндөр амжилт үзүүлсэн байна.

Чанарын үнэлгээгээр улсын дунджаас Дорнод аймаг монгол хэлний хичээлээр 3.5 хувиар дээгүүр, математик 1.4 хувь, физик 1.9 хувь, англи хэл 14.0 хувиар доогуур үнэлэгдсэн байна.


Сургуулиудын хувьд математикийн хичээлээр 13, монгол хэлний хичээлээр 11, физикийн хичээлээр 18, англи хэлний хичээлээр 20 нь сургууль улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байна.

Иймд дээрх хичээлүүдэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29 - ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 5 дугаар зүйл “улсын шалгалт, түүний зохион байгуулалт” 5.2 дахь “Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно” гэсэн заалтын дагуу жил бүр улсын шалгалтыг зохион байгуулдаг байна.

Сургуулиудын 2019 оны суурь боловсролын улсын шалгалтын дундаж үнэлгээг БҮТ-өөс 2019 онд 9 дүгээр ангиудад хийсэн аймгийн дундаж үнэлгээтэй хичээл бүрээр харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл №11 “Улсын дундажтай харьцуулсан үнэлгээ”





Хүснэгт №10 “Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалтын сүүлийн 3 жилийн дунджаар байр эзлэлт”

№	Сургууль	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Дундаж байр
1	FLOWER ахлах сургууль	1	1	1	1
2	Шинэ зуун ахлах сургууль	3	3	1	2
3	1-р ахлах сургууль	4	4	4	4
4	Гурванзагал сумын дунд сургууль	5	5		5
5	8-р ахлах сургууль	7	9	3	6
6	12-р ахлах сургууль	8	15	10	11
7	Шинэ хөгжил цогцолбор сургууль	8	15	10	11
8	Баян-Уул сумын ахлах сургууль	10	14	11	12
9	Дашбалбар сумын ахлах сургууль	11	12	12	12
10	Цагаан-Овоо сумын ахлах сургууль	11	9	7	9
11	5-р ахлах сургууль	13	11	6	10
12	Булган сумын дунд сургууль	13	8	15	12
13	Хан-уул цогцолбор сургууль	13	17	12	14
14	11-р ахлах сургууль	14	15	12	14
15	Баянтүмэн сумын дунд сургууль	15	12		14
16	Халх гол сумын ахлах сургууль	14	14	14	14
17	2-р ахлах сургууль	15	10	6	10
18	Чулуунхороот сумын ахлах сургууль	15	16	10	14
19	Ялалт багийн дунд сургууль	15	10		13
20	Сэргэлэн сумын дунд сургууль	17	13		15
21	Баяндун сумын ахлах сургууль	17	19	12	16
22	Чойбалсан сумын ахлах сургууль	17	18	17	17
23	Хөлөнбуйр сумын дунд сургууль	20	15		18
24	Матад сумын дунд сургууль	22	19		21

Аймгийн хэмжээнд бага, дунд, бүрэн дунд боловсролын улсын шалгалтын сүүлийн 3 жилийн дунджаар байр эзэлсэн дүнгээс харахад эхний 5 байрын хувьд хувийн сургууль 2, ердийн хэв шинжит 3 сургууль эзэлсэн байна.

ЭЕШ болон чанарын үнэлгээ, улсын шалгалтын дүнгүүдээр байнга доогуур үнэлэгдсэн сургуулиудад БСУГ-аас сургалтын чанарт тавих хяналт, арга зүйг нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Дүрслэл № 12. “Санал асуулгын дүн”



Санал асуулгад оролцогчдын 86.0 хувь нь “Сургалтын хөтөлбөр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна”, 75.0 хувь нь “Сургалтын удирдамж, арга зүй, гарын авлагаар бүрэн хангагдсан” гэж тус тус хариулсан нь сургалтын хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж байгааг харуулж байна.

Дүрслэл № 13. “Санал асуулгын дүн”



Дээрх 13 дугаар дүрслэлээс харахад сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цаашид анхаарах асуудалд 70.0 хувь нь сургалтын хөтөлбөр, сурах бичиг агуулгын хувьд зөрүүтэй, анги дүүргэлтээс шалтгаалан хичээлийн агуулгыг сурагчдад хүргэхэд хүндрэлтэй гэсэн байна.

- Нэмэлт сурах бичиг, гарын авлага ашигладаг уу? /салбарын яамны баталсан албан сурах бичгээс бусад нь хүүхдийн суралцах болон биеийн ачаалал, цүнхний жинд нөлөөлдөг эсэх/

Ерөнхий боловсролын сургуулиуд нь яамнаас баталсан сурах бичгийг ашиглаж байгаа бөгөөд багш нар зарим хичээлийн гарын авлагыг өөрсдөө бэлтгэж ангид ашиглуулдаг, номын сангаар нэмэлт сурах бичгээр үйлчилдэг байна.



Аймгийн Засаг дарга хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжиж тэдний бие махбод, эрүүл мэндэд учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/559 дугаар захирамж гарган бага ангийн сургагчдын цүнхний ачааллыг бууруулж дэвтэр, сурах бичгийг хүүхдийн жингээс 10 хувиас хэтрүүлэхгүй зохистой хэрэглэхийг захирамжилсан байна.

Захирамжийн хүрээнд Боловсрол, соёл, урлагийн газраас “сурагчийн цүнх” хэлэлцүүлэг зохион байгуулж мөн бага ангийн сурагчийн цүнхний ачааллыг бууруулах зөвлөмж гарган ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан нь сайшаалтай байна.

Аудитын явцад Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар эцэг, эхчүүдээс цахимаар санал асуулга авахад нийт 4828 эцэг, эхчүүд хамрагдсан.



Дүрслэл №14. “Санал асуулгын дүн “Танай хүүхэд ямар хичээлд нэмэлт ном, сурах бичиг ашигладаг вэ” гэсэн санал асуулгад нийт эцэг, эхчүүдийн 43.7 хувь нь *нэмэлт ном, сурах бичиг ашигладаггүй*, 35.3 хувь нь *математик*, 8.8 хувь нь *англи хэл*, 7.9 хувь нь *монгол хэл*, 4.3 хувь нь *физик, химийн* хичээлд сурах бичиг нэмэлтээр ашигладаг гэж хариулсан нь ахлах ангийн сурагчдын хувьд сонгон суралцах хичээлтэй холбогдуулан нэмэлт сурах бичиг ашиглаж байгаа нь нөлөөлсөн байна.

- Олон улсын сургалттай сургуулийн сургалтын хөтөлбөрийг БСШУСЯ, АНЗД хянаж, баталсан уу? /мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, хувийн сургууль/

Олон улсын сургалттай сургууль байхгүй.

Б.1.2 Сургалтын чанарыг бодитой үнэлж байгаа ч БҮТ-өөс дүгнэлтийг танилцуулах зөвлөмж өгч, чанарыг сайжруулах ажил хангалттай хийгдээгүй байна.

- ЕБ-ын чанарын үнэлгээний судалгааг бодитой, хэвшил хэв шинж харгалзахгүй бүрэн хамруулж хийж байна уу? /Төрийн болон хувийн сургууль, тусгай хэрэгцээт, хилийн чанад дахь, ОУ-ын хөтөлбөртэй сургуулиуд, МСҮТ, насан туршийн боловсролын газар зэргээр түүвэрт бүрэн хамруулсан уу/

Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17^{1.1}-т боловсролын үнэлгээний байгууллага нь бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх тухай заасан байдаг.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын




сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 6.2 дахь "Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна." гэсэн заалтын дагуу Боловсролын үнэлгээний төв нь жил бүр түүврийн аргаар сургуулиудыг сонгон суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшинг үндэсний хэмжээнд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, судалгааны үр дүнд тулгуурлан багшлахуй болон суралцахуйг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой судалгаа, чанарын үнэлгээг зохион байгуулдаг байна.

Дорнод аймгийн хэмжээнд Боловсролын үнэлгээний төвөөс хийгдсэн чанарын үнэлгээнд 2017 онд Хан-Уул, Шинэ хөгжил цогцолбор сургууль, Баян-Уул сумын ЕБС, 2018 онд Хан-Уул цогцолбор сургууль, Хэрлэн сумын 5 дугаар сургууль, Дашбалбар сумын ЕБС, 2019 онд суурь боловсрол буюу 9 дүгээр ангийн бүх суралцагчдыг хамруулсан бөгөөд нийт 22 сургууль хамрагдсан байна. Үүнд FLOWER хувийн сургууль хамрагдсан байна. Бусад 3 хувийн сургууль нь ахлах, бага сургууль учраас хамрагдаагүй байна.

"Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 6.3 дахь "Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна." гэж заасны дагуу жилд манай аймгаас 3 сургууль сонгосон ч хувийн хэвшлийн сургууль сонгогдоогүй байна.

Дүрслэл №15. "Санал асуулгын дүн



"Одоо мөрдөгдөж буй суралцагчийн болон сурлагын чанарын үнэлгээний журам хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж үнэлгээ бодитой хийгдэж байна уу" гэсэн асуултад нийт ажиллагсдын 65.1 хувь нь *хангалтгүй, учир дутагдалтай, сайжруулах шаардлагатай* гэж хариулсан нь уг журмыг шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

- *"Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бодитой үнэлдэг үү? /ЕБС-уудын байршил, өмчийн хэлбэр, багшийн ур чадвар, сургалтын орчин, хөтөлбөрийн олон удаагийн өөрчлөлтүүд, эцэг эхийн үүрэг оролцоо бага/ орон нутгийн боловсролын газрууд нөлөөллийн хүчин зүйлсийг тодорхойлдог эсэх/"*

Боловсролын үнэлгээний төв нь чанарын үнэлгээнд хамрагдсан сургуулийн сурагчдыг нийслэл, орон нутаг, дүүрэг, өмчийн хэлбэр, хэв шинж, хүйсээр нь ангилж харьцуулсан судалгаа, дүгнэлт хийдэг байна.

Мөн сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох зорилгоор сурагчдаас санал асуулгыг авсан байна.

Өрхийн орчин нөхцөл, өрхийн гишүүдийн харилцаа, найз нөхөд, нийгмийн харилцаа, сургуулийн орчин, багшийн харилцаа хандлага зэргээр судалгаанд хамрагдсан суралцагчдын сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйд шинжилгээ хийсэн байна.



Боловсролын үнэлгээний төв нь чанарын үнэлгээний дүн, судалгаа, тайланг боловсролын байгууллага, сургуулиудад ирүүлдэггүй байна.

Харин 2019 онд хийгдсэн суурь боловсрол буюу 9 дүгээр ангийн бүх суралцагчдыг хамруулсан чанарын үнэлгээний дүнг боловсролын үнэлгээний төвийн цахим сайтаас сургуулийн сургалтын менежерүүд өөрсдийн кодоор орж мэдээллээ авдаг болсон байна.

Дүрслэл №16. "Санал асуулгын дүн



"Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг үү" гэсэн асуултад нийт ажиллагсдын 52.6 хувь нь *тийм*, 33.1 хувь нь *тодорхой хэмжээнд хийгдэж эхэлсэн*, 14.3 хувь *үгүй*, гэж хариулсан нь сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэх ажил хийгдэж байгааг харуулж байна.

Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч үр дүнг тооцож ажиллахгүй байна.

Б.2.1 Байгууллагын түвшинд дотоод хяналт бүрэн хэрэгжихгүй, үр дүнг тооцохгүй байна.

- "Салбарын яамны хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу? /Боловсролын хүрээлэн, үнэлгээний төв, ЕБГ/"

БСШУ-ны яам, Боловсролын хүрээлэн, БҮТ-өөс хамтарсан баг 2017-2019 онуудад жилд 1-2 удаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хэлэлцүүлэг, сургалтуудыг хийсэн байна.

Үүний үр дүнд хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө агуулгын нэгдсэн ойлголтод хүрэх, үр дүнгээ тооцох, багшийн сайн туршлагыг түгээх, хүнд болон хүндэвтэр хичээлийг хамтран зохион байгуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэн сурагчдын сурлагын ахиц дэвшилд эерэг өөрчлөлтүүд гарсан үр дүнтэй байна.

- Орон нутгийн боловсролын газрын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцож байна уу? /яамны болон хөндлөнгийн/
- Сургалтын хөтөлбөрт тавих шат шатны хяналт хэрэгжиж байна уу? /төрийн болон хувийн өмчийн/

Боловсролын тухай хуулийн 28.1.4-д заасны дагуу аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар нь боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх чиг үүргээ хангалттай түвшинд хийсэн нь аудитын явцад хийсэн ярилцлага, ажиглалт, санал асуулга, тайлан, баримт материалаас харагдаж байна.



Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан эсэхийг үзэхэд тус газар нь зөвлөн туслах чиглэлээр дотоодын хяналт үнэлгээ хийх ажлын удирдамжийн дагуу 2017-2019 оны хичээлийн жилд аймгийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудад Боловсролын тухай хууль тогтоомж, Цөм /сайжруулсан/ сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, орон нутгаас хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд сургуулиудад цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж чиглэл өгч, холбогдох дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Зөвлөн туслах ажлын хэсгээс хүргүүлсэн дүгнэлтийн дагуу холбогдох сургуульд зөрчил дутагдлаа арилгасан тухай ажлын тайланг тухай бүрд ирүүлсэн байна.

- *Байгууллагын түвшинд дотоод хяналт хэрэгжиж байна уу? /ерөнхий боловсролын сургуулиуд/*

Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийх аудитын хүрээнд нийт 20 ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын ажлыг үзэж шалгахад ажлын төлөвлөгөө, тайлан байгаа боловч хэрэгжүүлсэн зарим ажлууд нь баримтаар нотлогдохгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна. Мөн зарим сумдад дотоод хяналтын ажилтанг томилоогүй зөрчил илэрсэн. Тухайбал: Гурванзагал сумын ЕБС нь 2014 оноос хойш дотоод хяналт хариуцсан ажилтангүй, томилсон тушаал, төлөвлөгөө, тайлан байхгүй боловч дотоод хяналтын ажилтны чиг үүргийг нийгмийн ажилтан давхар хариуцаж ажилласан байна.

- *Салбарын яамнаас багш бэлтгэж буй их дээд сургуулийн хөтөлбөр, чанарт тавих хяналт үр дүнтэй байна уу? /магадлан итгэмжлэл/*

Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12-т “Дээд боловсролын сургалтын байгууллага хөтөлбөрөө сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ,” гэж заасны дагуу Дорнод их сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд Боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр 3 хөтөлбөр магадлан итгэмжлүүлсэн байна. Үүнд багш, бага ангийн боловсрол 5 жилийн хугацаатай, багш, сургуулийн өмнөх насны боловсрол, нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрүүд тус бүр 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлэх эрх авсан байна.

Дорнод их сургуулийн хувьд багшийн мэргэжлийн нийт 8 хөтөлбөр байгаагаас 3 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж, бусад хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлүүлэхээр холбогдох материалын хамт БШУЯ-нд хүргүүлсэн байна.

БШУЯ-наас их, дээд сургуулиудаас сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасантай холбоотой сургалтын хөтөлбөрт хяналт, шалгалтыг зохион байгуулдаг байна. Сургалтын хөтөлбөрийн явц, түүний чанарт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.2.2 Эцэг эхийн зөвлөлийн хяналт хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байна.

- *Мэргэжлийн байгууллагуудын зүгээс үр нөлөөтэй хяналт шалгалт хэрэгжүүлж байна уу?*



Мэргэжлийн байгууллагуудын зүгээс сургуулиудад хөндлөнгийн хяналт хийгдсэн байна.

Тухайлбал:

- МХГ-аас орчны аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын хөтөлбөр, стандартын чиглэлээр,
- Санхүүгийн хяналт аудитын албанаас ЕБС-иудын санхүүгийн үйл ажиллагаанд,
- БСУГ-аас боловсролын байгууллагын үйл ажиллагаанд бүхий л чиглэлээр,
- ОБГ-аас галын аюулгүй байдал,
- ЭМГ-аас суралцагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ,
- ОНӨГ-аас эд хөрөнгө, түүний ашиглалт, бүртгэл,
- Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс бодлогын баримт бичгийн хэрэгжилтэй холбоотой хяналт, шалгалтуудыг хийсэн нь аудитын явцад хийсэн ярилцлага, ажиглалт, тайлан, баримт материалаас харагдаж байна.

- *Эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалттай, үр дүнтэй байна уу?*

Бага дунд боловсролын тухай хуулийн 20.1.4 дэх “сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу нийт сургуулиуд нь эцэг эхийн зөвлөлийг байгуулсан байна. Сургуулиудын эцэг эхийн зөвлөл ажилласан гэх боловч нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь сургуулиудын дотоод зохион байгуулалт, эцэг, эхчүүдийн үүрэг оролцоо бага, идэвхи санаачлага муу байгаатай холбоотой байна.

Иймд цаашид эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Хууль тогтоомжид заасан эцэг, эх, асран хамгаалагчийн хүлээх үүргээ бүрэн биелүүлдэг үү? санал асуулгад нийт 4828 эцэг эх оролцсоны 557 үгүй бусад хүчин зүйлийн улмаас бүрэн биелүүлэх боломж хомс, 4119 тийм, бүрэн биелүүлдэг, 152 мэдэхгүй, ямар үүрэг хүлээдэг талаар тодорхой ойлголтгүй байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

*А.Атгалмаа:
Аудитын тайлан
гүтгэгчээр
саналын
тайланг
хавьцнаар.
2020.10.28*


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584
2020.10.28 № 42120
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Таны амгаланг айлтгая.

Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу Дорнод аймгийн "Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Цаашид өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.

Хүндэтгэсэн,

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ш.ЁЛ



010620657



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

21071, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас: 7058-3674

2020.10.27 № 351
танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Б.Нансалмаа:
Тайлбар саналтай
мөнхийн судлаач ажилтан
тайланг нугамд оруул.
2020.10.27

Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн аудитын тайлан, урьдчилсан дүгнэлттэй танилцаж, дараах нэмэлт саналыг Танд хүргүүлж байна. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлтөд баримталж буй нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын нормативыг бодит нөхцөлд нийцүүлж жил бүр шинэчлэн тогтоож, Засгийн газраар батлуулах,

2.Засгийн газрын 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 3.12, 4.5 дахь заалтад сар бүр гэж заасныг хагас, бүтэн жилээр тооцох гэж өөрчлөх зөвлөмжийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд уламжлах,

3.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, сар бүрийн санхүүжилтыг олгож байгаа ч, төсвийн тухай хуулинд зааснаар аймгийн Засаг дарга тухайн байгууллагын төсөвт зохицуулалт хийх эрхтэй. Гэсэн хэдий ч сумын Засаг дарга нар хуулиар олгогдоогүй эрх эдэлж, сургуулиудын төсөвт зохицуулалт хийсэн нь аудитын дүгнэлтээр тогтоогдсон тул хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сумын Засаг дарга нарт зөвлөмж өгөх,

4.Эцэг эхийн үүрэг, оролцоог шинэ шатанд гаргах, үр дүнг нэмэгдүүлэх талаар гаргасан дүгнэлт, зөвлөмжтэй санал нэгдэж байгаа бөгөөд сургуулийн эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар салбарын Яам болон аймгийн бодлогын хүрээнд хийгдэж буй олон талт ажлын эхлэл, үр дүн, сайн туршлага хуримтлагдаж байгаа билээ. Бид дотоодын хяналт, шинжилгээ хийх явцад аймгийн сургуулиуд Эцэг, эхийн зөвлөлийн ажиллах журам, хамтын гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, Эцэг, эх зохицуулагч арга хэмжээний хуваарь, тайлан зэргийг гаргасан байдаг. Энэ талаар хийгдэж буй ажлын нотлох баримтуудыг дахин нягталж өгнө үү.

ДАРГА



А.НАНСАЛМАА

390520056



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. ЗГ-ын тогтоолоор баталсан хувьсах зардлын ангилал, норматив, аргачлалд өөрчлөлт хийгдээгүй, өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй байгаа тул шинэчлэх саналыг холбогдох газар уламжлахыг УАГ-т хүргүүлээ.

2. Сумдын Засаг дарга нарт хууль зөрчиж төсөвт зохицуулалт хийхгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг өглөө.

3. Сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж удирдлагуудтай уулзалт, ярилцлага хийх явцад эцэг эхийн зөвлөлийг байгуулсан, ажилласан гэх боловч үр дүнг нотлох баримт хангалтгүй байсан тул дүгнэлт, зөвлөмжийг хэвээр үлдээлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. БСШУЯ нь Боловсролын тухай хууль, тогтоомжид заасан журмуудыг бүрэн батлаагүй байна.
2. Багшийн ажлын норм, нормативтай холбоотой хууль, дүрмийн заалтуудыг бага боловсрол олгох бодлого, хөтөлбөртэй уялдуулах шаардлагатай байна.
3. Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчин бүрдсэн ч шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалж хамрагдалт харилцан адилгүй байна.
4. Ерөнхий боловсрол олгоход шаардлагатай материаллаг орчин хангалттай бүрдээгүй байна.
5. Аймгийн хэмжээнд зарим мэргэжлийн багш нар дутагдалтай байна.
6. Төсвийн төлөвлөлтөд баримталж буй норм, норматив бодит нөхцөлд нийцэхгүй, аргачлал дутмаг байгаагаас хуваарилалт тэгш хүртээмжтэй хийгдэхгүй байна.
7. Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил гарсаар байна.
8. Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч суурь боловсролын чанар хангалтгүй дүгнэгдсэн байна.
9. Сургалтын чанарыг бодитой үнэлж байгаа ч БҮТ-өөс дүгнэлтийг танилцуулах зөвлөмж өгч, чанарыг сайжруулах ажил хангалттай хийгдээгүй байна.
10. Байгууллагын түвшинд дотоод хяналт бүрэн хэрэгжихгүй, үр дүнг тооцохгүй байна.
11. Эцэг эхийн зөвлөлийн хяналт хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байна.

Аудитаар мөнгөн дүнгээр нийт 10.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, ЕБС-ийн үйл ажиллагаа, хүний нөөц, гадаад болон дотоод орчин, хяналт, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалттай холбоотой 5.5 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж, 4 санал хүргүүлж ажиллалаа.



САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар БСШУЯ-нд уламжлах. Үүнд:

1. Боловсролын тухай хуульд заасан журам, дүрмийг бүрэн боловсруулан батлах. /Боловсролын тухай хуулийн 28.1.25, 39.12/
2. Ерөнхий боловсролын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зарим хууль, дүрэм, журмын заалтуудын уялдааг хангах. /Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.4, Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журмын 4 дэх заалт/
3. Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан хувьсах зардлын ангилал, норматив, аргачлалыг бодит нөхцөлд нийцүүлэн шинэчлэх.
4. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. а. Хэрлэн сумын 11-р сургуулийг зориулалтын барилгатай болгох асуудлыг нэн түрүүнд шийдвэрлүүлэх, сургуулиудын өргөтгөл болон их засварын ажлыг шат дараатайгаар төсөвт тусган шийдвэрлэх, чанаргүй хийгдсэн сургуулиудын барилга, засварын ажлуудыг дахин гүйцэтгүүлэх.
- б. Ерөнхий боловсролын сургуулиудын ойр орчимд хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байгаа асуудлуудыг холбогдох аж ахуйн нэгжид хандаж шийдвэрлүүлэх.

БСУГ-ын дарга А.Нансалмаад:

1. Хүүхэд бүрийг хамран сургалтад бүрэн хамруулах боломжийг нэмэгдүүлж, хүчин чадал, нормоос хэтэрсэн зарим сургуулиудын ачааллыг багасгаж, бусад сургуулийн ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авах.
2. Дутагдалтай байгаа мэргэжлээр багшлах боловсон хүчин бэлтгэх бодлого, менежментийг сайжруулах.
3. Бүх суралцагсдад заавал эзэмших суурь боловсролыг жигд олгоход түлхүү анхаарч ажиллах.
4. Төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудад улсаас олгож буй зардлын төсвийг бодитой төлөвлөж, хуваарилах.
5. Нормативт зардлын санхүүжилтийг сар бүр хүүхэд өдрөөр хянах.



Сургуулиудын захирлуудад:

1. Ерөнхий боловсролын сургуулиуд гадаад, дотоод орчны аюулгүй байдлын эрсдэлийг MNS-6782:2019 стандартын дагуу үнэлж, эрсдэлтэй үзүүлэлтүүдийг бууруулахад анхаарч ажиллах.
2. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, анги танхимыг кабинетжуулах талаар идэвх санаачилгатай ажиллах.
3. Бүх суралцагсдад эзэмшүүлэх суурь боловсролын чанарыг сайжруулахад анхаарч ажиллах.
4. Сургуулиудын дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.
5. Эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах.

Сүмдын Засаг дарга нарт:

1. ЕБС-иудын төсөвт Төсвийн тухай хуулийг зөрчиж зохицуулалт хийхгүй байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 46

Чойбалсан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тавигдсан төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.
3. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга А.Нансалмаа нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110219141



Тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар
сарын 29-ний өдрийнх тоот тушаалын хавсралт

Төлбөрийн актны жагсаалт

2020.10.29.

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актны утга	Мөнгөн дүн /мян.төг/
1	Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургууль	ДОА-2020/03-ГА	Хоолны зардлыг илүү тооцон олгосон	1,111.2
2	Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль	ДОА-2020/03-ГА	Хоолны зардлыг илүү тооцон олгосон	3,815.1
Нийт дүн				4,926.3



Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn